онцгой дэглэмийн болон эрүүл ахуйн бүс, усны эх үүсвэрийн тэжээгдлийн дотоод мужид авах арга хэмжээ, үйл ажиллагаа, ашиглалт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Энэ талаар гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа наад захын асуудал нь голуудын хамгаалалтын бүс, усан сангуудын газар ашиглалт, өмчлөлийн байдал нь хуулийг ноцтой зөрчиж, хотын унд ахуйн усан хангамжийн газрын доорх эх үүсвэр бохирдох эрсдэлийг бий болгож байна. Тийм учраас усны эх булгийн тэжээгдлийн дотоод мужийн хамгаалалтын бүсийн газрыг чөлөөлөх, ойролцоох ус бохирдуулах эх үүсвэрүүд (шатахуун түгээх станцууд, арьс, шир боловсруулах үйлдвэр, эмийн үйлдвэр, барилга, тавилгын үйлдвэр, авто машины түр зогсоол, ус дамжуулах төв, туслах шугамын дагуух барилгын болон ахуйн хог хаягдал)-ийг яаралтай нүүлгэх асуудал тулгамдсан асуудал болсон байна.

Иймд хотын бохир ус цэвэрлэх Төв цэвэрлэх байгууламжийн технологийг иж бүрэн шинэчлэх, өндөр технологи нэвтрүүлэх, цэвэрлэсэн бохир усыг норм, стандартад нийцүүлэн унд хүнснээс бусад салбарт эргүүлэн ашиглах асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

Гэр сууцны хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагаас ялгарч байгаа ахуйн бохир усыг бага оврын цэвэрлэх байгууламжинд гүн цэвэрлэж цэвэрлэсэн усыг гудамж талбай, зүлэг ногоо услах эсвэл гудамжны тоос дарах зэрэгт ашиглах төлөвлөлтийн шийдлийг гаргах хэрэгтэй. Гэр сууцны хорооллын оршин суугчдын ялгаруулж байгаа физиологийн бохирдуулагч /өтгөн, шингэн ялгадас/-ийг цуглуулах, цэвэршүүлэх бага ба дунд хүчин чадлын бие даасан болон хэсэгчилсэн байгууламж ашиглах төлөвлөлтийн шийдлийг гаргах хэрэгтэй байна.

Хот суурины цэвэрлэгээ, хөрсийг бохирдлоос хамгаалах: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хөрсийг бохирдлоос хамгаалах “төлөвлөлт –технологи -эрүүл ахуйн” арга хэмжээний хүрээнд хатуу, шингэн хог хаягдлыг эрүүл ахуй, барилга төлөвлөлтийн нормд заасан хэмжээг харгалзан хотын хог хаягдлын цэвэрлэгээ, цуглуулалт, тээвэрлэлт, устгалт, цэвэршүүлэлтийн чадамжийг тооцоолж, тохилог орон сууцанд нэг хүн 200 гр/хоног хатуу хог хаягдал, 250 л бохир ус ялгарахаар, гэр хороололд нэг хүн 720 гр/хоног хатуу хог хаягдал, 40 л шингэн хаягдал болон өтгөн, шингэн ялгадас жилд 0.5м³ ялгарахаар тус тус тооцож, хог хаягдлыг цэвэрлэх байгууламжийг төлөвлөх хэрэгтэй. Эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагын эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хотод I шатлалын өрхийн эмнэлэг 110, II шатлалын эмнэлэг 9 дүүрэгт, тусгай мэргэжлийн III шатлалын 10 эмнэлэг тус тус ажиллаж байна. Эдгээр эмнэлгүүдээс сэтгэцийн эмгэг судлалын төвийн архаг болон асрамжийн үйлчилгээнд хамаарах үйлчилгээний тасаг, хавдар судлалын эмнэлгийн туяа эмчилгээний тасаг, мөн халдвартын эмнэлгийн зарим тасгуудыг хот орчмын бүсэд шилжүүлэх шаардлагатай болсон байна.

Хотын мал амьтны тоо, байршил, нөлөөлөл: Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод гарсан мал, амьтны гаралтай шүлхий, боом, гахай, шувууны ханиад зэрэг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэх шаардлага тулгамдсан асуудал болсон байна.

Монгол улсын Засгийн газраас нийслэлд мал аж ахуй эрхлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, худалдах явдлыг эмх цэгцтэй болгох, хүн, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг 2002 оны 133 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг дарга 2002 онд 411 тоот захирамжаар “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг батлан, мал аж ахуй эрхлэхийг хориглох

бүсийг урд тал нь Айдасын даваа, баруун тал нь Морин-Уул, Өвөрхангай, Сэлэнгэ, Алтанбулагийн чиглэлийн засмал замын уулзвар, хойд тал нь Тахилт, Гүнтийн даваа, зүүн тал нь Улиастай гол, Налайх-Тэрэлжийн засмал замын уулзвараар хязгаарлан тогтоосон боловч хэрэгжилт хангалтгүйгээс хүн амыг гоц халдварт өвчнөөс хамгаалах нөхцөл бүрдээгүй учраас хотын нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх нутаг дэвсгэрийг тусгайлан тогтоож хөгжүүлэх шаардлагатай.

2010 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт 262881 толгой мал тоологдсон 2009 оныхоос /400825 мал, 284563 гахай, шувуу/ 34.4 хувиар буюу 137944 толгой малаар буурсан байна.

2010 онд мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн малын тоо 18970 байсан нь өмнөх оноос 26.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1.4.2.2. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын тоо, дүүргээр

Дүүргийн нэрс	2009 он	2010 он	үүнээс :				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Баянгол	26	32	-	6	26	-	-
Сүхбаатар	4523	3842	-	318	2528	348	648
Чингэлтэй	2419	1507	-	28	895	138	446
Баянзүрх	5087	3061	-	80	982	801	1198
(11,20-р хороо ороогүй)							
Сонгинохайрхан	8559	7190	3	121	3199	1468	2399
(20,21-р хороо ороогүй)							
Хан-Уул	5218	3338	1	167	1239	812	1119
(12,13,14-р хороо ороогүй)							
Дүн	25832	18970	4	720	8869	3567	5810

Хөдөө аж ахуйн тэжээвэр амьтад: Мал, тэжээвэр амьтдын тооллогоор 103 өрхийн 2361 гахай, 16 аж ахуйн нэгжийн 10550 гахай, 219 өрхийн 11287 шувуу үүнээс 10938 тахиа, 8 аж ахуйн нэгж, байгууллагын 267110 шувуу үүнээс 267021 тахиа, 2 илжиг, 23 өрхийн 180 туулай, 3 өрхийн 53 бүл зөгий тоологдсон байна. Өмнөх оны тооллогын дүнгээс гахайн тоо 4.7 хувиар, шувууны тоо 2.3 хувиар өсчээ.

Эдгээр амьтдыг малын хамтаар тогтоол, журам, захирамжид заасан нутаг дэвсгэрт тоо толгойг нь өсгөх биш, ашиг шимийг нь дээшлүүлэх зорилгоор дагуул хот, тосгодод төрөлжүүлэн үржүүлж, хотын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх аж ахуйн хэлбэрээр эрхлэхээр төлөвлөх хэрэгтэй юм.

Хөдөө аж ахуйн хог, хаягдал ба нөлөөлөл: Улаанбаатар хотын орчимд байгалийн голомтот халдварт өвчин сүрьеэ, бруцеллөз, боом, галзуу, сальмонеллөз, цусан халдвар, гахайн мялзан, хонины цэцэг, шувууны ханиад гэх мэт өвчний голомт зарим аж ахуй болон мал бүхий иргэдийн мал амьтнаас оношлогдож, халдваргүйжүүлж, эрүүлжүүлэх тохиолдол гарч байгаа нь хүн амын 47% нь амьдарч байгаа нийслэлийн төдийгүй улс Үндэсний Аюулгүй Байдалд нөлөөлөх онцгой аюултай, хортой, муу нөлөөтэй, анхаарвал зохих чухал асуудал юм

Хөдөө аж ахуйн хог, хаягдал гэдэг нь хот, суурингийн хог, хаягдлаас тусдаа хяналтгүй аюултай, хортой, муу нөлөөтэй болгоомжлох хог хаягдлын ангилалд ордог ба мал, амьтны сэг, зэм, шинжилгээгүй арьс, нэхий, ноос, ноолуур, хаягдал дотор эрхтэн, ялгадас зэрэг багтдаг бөгөөд хөдөө аж ахуйн хог хаягдлын нарийвчилсан судалгааг гаргаж хог, хаягдал устгах, хог, хаягдлын цогц (5R) менежментэд хамруулан цуглуулах, тээвэрлэх, дахин бэлгэх, боловсруулах, үлдэгдэлгүй зохистой устгах шинэ тогтолцоог

бий болгох хэрэгтэй гэж “Эх орон цэвэр байгаль” ХХК-ний Судалгаа хөгжлийн төвийн судалгааны тайланд тодорхойлсон байна.

1.4.2. Гамшгийн менежмент

Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага нь гамшгийн давтамж, эрчим нэмэгдэхэд нөлөөлөх магадлалтай бөгөөд гамшигт өртөх өндөр эрсдэлийг бий болгож байна. Дэлхийн хүний хөгжлийн 2010 оны илтгэлд дурьдсанаар нэг сая хүнд ногдох байгалийн гамшигт өртсөн хүний тоогоороо Монгол улс Свазиландийн дараа хоёрт орж байна. /ХХИлтгэл 2011 он/ Улаанбаатар хотын хувьд анхааран шийдвэл зохих байгалийн гамшгийн нэг нь үер усны аюул юм. Энэхүү гамшиг нь хөрс усыг шингээх чадвар буурснаас үүдэн тохиолддог. 2010 оны байдлаар үерийн ус зайлуулах суваг, хамгаалалтын далан 5.1 км, гадагуугийн ус зайлуулах 15.6 км шугам сүлжээ, үерээс хамгаалах барилга байгууламж байна. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд 2010 оны түвшинд уруйн үерээс хамгаалах 31,6 км далан суваг, гадаргуугийн урсацыг зайлуулах 32,8 км далд шугам, ховор тохиолдох үерийн 11,5 км далан, 15 км хөрсний уснаас хамгаалах далан барихаар төлөвлөгдсөн. Гэвч үерийн хамгаалалтын байгууламжийн 30% нь баригдаж үүний 70% нь эвдэрч хуучран болзошгүй аюулыг даах чадваргүй болсон.

Хүснэгт 1.4.2.1. Үерийн ус зайлуулах сувгийн одоогийн байдал

Д/д	Үерийн ус зайлуулах суваг	Баригдсан он	Байршил урт, өргөн,гүн	Хамгаалалтын зурвас
1.	Чингэлтэйн суваг.	1986 онд Чингэлтэйн голыг суваг болгон өөрчилсөн.	урт 2140 м өргөн нь 13 м.	Сувгийн бэхэлгээний бетон хавтангууд ховхорч эвдэрсэн, элс шороо ахуйн хог хуримтлагдсан учир үерийн усыг өнгөрүүлэхэд хүндрэлтэй болсон тул сувгийн зураг төслийг шинээр хийж 2011 онд угсралтын ажлыг эхэлсэн.
2.	Хайлаастын суваг.	1982 оны үерийн дараа барьсан.	Урт 2485 м өргөн нь 10 м, гүн нь 1,6 м.	Суваг бүрмөсөн эвдэрсэн, суваг руу шахаж хашаа байшин барьсан, ахуйн хог хаясан зэрэг нь үерийн аюулыг ихэсгэж байна.
3.	Дэнжийн 1000-ын 1, 2, 3-р суваг.	2000-2002 онд барьсан. Дэнжийн 1000-ын эдгээр сувгуудын усыг Ногоон нуурт нийлүүлдэг.	Далан давхрын энгэрийн сайр жалгуудаас ирэх үерийн усыг Ногоон нуурт нийлүүлэхээр НАА-н I төслөөр барьсан. урт 1186м ёроолын өргөн 15 м, гүн нь 2,0 м орчим II суваг нь угсармал төмөр бетон доторлогоотой, сувгийн ёроолын өргөн ба гүн нь 1,0 м, нийт урт нь 1167 м, III сувгийн урт 1445 м,	I суваг ахуйн хог ихтэй, зуны улиралд 39-р сургуулийн урд талын зам дээр хүмүүс машин угааж бохир усаа суваг руу асгаж сувгийг эвдэх II суваг 32-ын тойргоос баруун тийш хэсэг маш зузаан лаг шавар, ахуйн хогтой, сувгийн ирмэг дээгүүр хашаа хатгаж суурьшсан байгаа нь нийтдээ гулсалтанд орж нурж болзошгүй болсон. Хүчит шонхор хүнсний захын орчимд III сувгийн бэхэлгээний хавтангууд ховхорч эвдэрсэн ахуйн хогтой, 32-ын тойргоос баруун тийш сувгийн өргөн 1,0 м болж нарийссан байгаа нь үерийн усыг өнгөрүүлэх боломжгүй байдалтай.
4.	Ногоон нуур.	1957 оны үед Дэнжийн 1000 орчмын булаг		Нуур эргэн тойрондоо гэр хороололд шахагдаж ус гаргах хэсгийг бүрмөсөн дарж битүүлэн далан дээгүүр нь хашаа барьсан,

	шанд баруун Сэлбэ голын усыг хуримтлуулан амралт зугаалгын бүс болгож бичил уур амьсгалыг бий болгох зорилгоор барьсан.		илүүдэл ус хаях барилга маш их эвдэрсэн лаг шавартай ахуйн хогонд дарагдаж хогны хонхор болгох дөхсөн. Мөн нуураас нэвчсэн шүүрэлтийн ус хөрсний усыг баяжуулж байгаагаас 6-р хорооллын орон сууцны 33, 35, 40, 42, 49, 54-р байруудын хонгилд устай болсоор удаж байна. Далангийн дотор гадна налуу, ёроол нь төслийн хэлбэр хэмжээгээ бүрмөсөн алдсан.
5. Баруун уулын суваг.	Хотын баруун, баруун хойд хэсгийг үер уснаас хамгаалах зориулалтаар баригдсан гол байгууламж бөгөөд Дэнжийн 1000-ын сугуудын усыг Ногоон нуураас баруун уулын сувагт дамжуулах үүрэгтэй	урт нь 12,8 км	Баруун уулын суваг нь хотод ашиглагдаж байгаа сугуудаас хүний ахуйн үйл ажиллагааны нөлөөнд хамгийн их өртөж эвдэрсэн суваг болно. Энэ нь, барилга байгууламжийг үерийн хамгаалалтын суваг, далангаас 15 м зайд байрлуулах хуулийн заалт маш их зөрчигдөж байгааг харуулж байна. Гандангийн дэнжийн зүүн болон урд талаар баруун уулын сувагт хашаа байшинг хэт ойртуулж барьснаас 2003 оны үерээр мөргөцгийн хэсэгт нурулт үүсч сувгийн бэхэлгээний хавтан эвдэрч, нурж байсан. Мөн баруун 4 зам, MAXMALL худалдааны төвөөс баруун тийш сувгийн налуу руу маш их шахаж барилга барьснаас налуугийн төслийн хэлбэр хэмжээ алдагдан ус урсахгүй тунаж байна. Чингүнжавын гудамжны автозамтай огтлолцсон хэсэгт сувгийн трасс дээр 9 давхар сууц барьсан байгаа нь сувгийг томсгох буюу засвар үйлчилгээ хийх боломжгүй болгосон байна.
6. 3,4-р хорооллын арын суваг.	1982 он 3-р хорооллын арын гэр хороолол дундуур урсан 1- р хорооллын зүүн хойт хэсгээс баруун уулын сувагт нийлдэг.		Сувгийн эхэнд Далан давхарын энгэрийн сайраар урсаж ирэх үерийн усны хагшаасыг тогтоох далантай, ашиглалтанд орсноос хойш төслийн хэмжээнд хүртэл хагшаасыг цэвэрлэж байгаагүй учир цөөрмийн хэсэг хагшаасаар дүүрч ёроол нь нэлээд өргөгдсөн учир 2005 оны үерээр ус далан дээгүүр хальж, сувгаас дооших айлууд нь үерт орж хүний амь эрсдэж байсан. Одоогоор суваг нийт уртынхаа дагууд 30-80 см лаг шавартай учир үерийн тооцоот зарцуулгыг өнгөрүүлж чаддаггүй ба тухайлбал Баянгол дүүргийн 9-р хорооны хэсэгт хальж, нам газарт байгаа айлууд үерт орж байсан.

Хотын хойд уулархаг хэсэг, усны эх, ай савд ой модыг огтлон ихээр сүйтгэж хүн ам олноороо суурьшин, хот улам тэлсээр байгаа нь анхаарал хандуулах хойшлуулшгүй асуудал болсон. Иймд өнгөрсөн хугацаанд үер усны аюулд нэрвэгдэж байсан тохиолдлуудын бүртгэл мэдээлэлд тулгуурлан, үер усны эрсдэлийн бүсийг нарийвчлан тогтоож тухайн нутаг дэвсгэрт суурьшил үүсгэхийг хатуу хориглох асуудлыг газрын менежментэд чухалчлан авч үзэх шаардлагатай.


Үүнээс гадна болзошгүй гамшгийн нэг нь газар хөдлөлт юм. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд оршдог.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт үүсэх магадлал бүхий голомт идэвхжиж, Эмээлт болон Сонгино орчимд 30 орчим км урттай, 13 орчим км гүний хэмжээтэй томоохон талбайг хамарч байгаа нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон.

1.4.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт, хамгаалалт

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар: Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт нийт 293168,0 га талбайг эзлэн, Улаанбаатараас зүүн тийш 50-76 км газарт байрладаг.

Дүрслэл 1.4.3.1. Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолбор газар



Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын нутаг дэвсгэр болох Өвөр Горхи, Тэрэлжид зун намрын улиралд Улаанбаатар, Налайх дүүрэг, Гачуурт хорооноос айл, мал ихээр ирж ямарч зөвшөөрөлгүйгээр зусч, намарждагаас бэлчээр талхлагдан

доройтох, улмаар элдэв хог хаягдлаар дүүрч, замбараагүй байдал гарах гол нөхцөлийг бүрдүүлж байдаг.

Дархан цаазат Богдхан уулын байгаль экологи: Богдхан Уул 1994 онд Дархан Цаазат Газраар (ДЦГ) тодорхойлогдож, 1997 онд Богдхан Уул Шим мандлын бүс (UNESCO) газраар зарлагдсан дэлхийн хамгийн эртний хамгаалалттай газар юм. Энэ уул нь Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээр, хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Дархан цаазат Богдхан уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268.0 өндөрт өргөгдсөн 41348.54 га талбайг эзлэн оршдог Цэцээ гүн юм. Энэ ууланд эмчилгээний ач холбогдолтой хэд хэдэн рашаан булгууд байдаг.

Сүүлийн жилүүдэд Зайсан толгойн аманд барилгажилт эрчимтэй нэмэгдэж аялал жуулчлалын зарим үйл ажиллагаа, идэвхжиж байгаагаас харахад хотжилт нь тусгай хамгаалалттай газруудад сөрөг нөлөө үзүүлж байна. Дэлхийн байгаль хамгаалах сангийн /2010/ баримт бичигт тэмдэглэснээр сүүлийн жилүүдэд Богд хан уулын нийт 21 аманд олон давхар орон сууцны хороолол, хиймэл цас ашиглах цанын 5 бааз, 18 нүх бүхий гольфийн талбай, орон сууцны цогцолбор газрууд болон аялал жуулчлалын зориулалттай олон барилга барих зэргээр барилгажилт, тохижилтын үйл ажиллагаа явагдаж тусгай хамгаалалттай газар нутгийн хуультай зөрчилдөж байна.

Гандантэгчилэн хүрээ хийд орчмын 57 га газрыг 2001 онд УИХ-ын тогтоолоор тусгай хамгаалалтанд авсан. Өнөөдөр Гандан хороололд 900 орчим айл өрх амьдарч байгаагийн 90 орчим хувийн газар нь өмчлөгдсөн байгаа нь мөн л хуультай зөрчилдөж байдаг.

Í èéñéýèèí òýì æýýí ä î ðí í í òò äèèí ò òñääé òàì äääèèèò àí ä äåñàí äàçàð í òò äóóä:

- “Баянзүрх хайрхан”-û ä í ÈÕÕ-ûí 1997 ííû 07 ñàðûí 23-ны өдрийн 50 тоот тогтоолоор байгалийн цогцолбор газарт;
- ÑÕÄ-èèí í òààäýàñäýð äýð Õàì áúí í âíííû Õýèí ýæýñäèèí äóðñäèè äðçí äýðäýð òí äüí èáí ð äàçäü ä í ÈÕÕ-ûí 2008 ííû 09 ñàðûí 22-íû °äðèèí 141 òí î ò òí äüí èíí ð í ðí í í òòäèèí òàì äääèèèòàí ä äåñàí .
- ÑÕÄ-èèí í òí ðíííû í òààäýàñäýð äýð Ääýí ä èüí ò°í äèèä2006 ííû 06 ñàðûí 20-í û 152 òí î ò òí äüí èíí ð ääèèèèèí òí äüí èáí ð äàçàðð;
- “Чингэлтэй хайрхан”-û ä ×èí äýèðýé äçðäèèí ÈÕÕ-ûí 2006 ííû 05 ñàðûí 19-í èè °äðèèí 22 òí î ò òí äüí èíí ð òñ òñ òñäèèí òàì äääèèèòàí ä äåñàí ääèí ä.


II БҮЛЭГ. ГАЗАР АШИГЛАЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Газрын нэгдмэл сангийн ангилал

Нийслэлийн газрын нэгдмэл сангийн ангиллын бүтэц: 1-дүгээр зурагт үзвэл 2009 онд 470444 га байсан нь 2000 онд 265980.1 га байсан бөгөөд 57%, 2-дүгээр зурагт үзвэл 41084.5 га байсан нь 2000 онд 9%, 3-дүгээр зурагт үзвэл 5679.0 га байсан нь 1%, 4-дүгээр зурагт үзвэл 76966.8 га байсан нь 16%, 5-дүгээр зурагт үзвэл 4078.1 га байсан нь 1%, 6-дүгээр зурагт үзвэл 76655.4 га байсан нь 16%-ийг эзэлж байна.


Улаанбаатар хотын хот суурингийн газар нийт нутаг дэвсгэрийн 7.4 хувийг эзлэх ба үүний тэн хагасаас илүү нь барилга байгууламжийн доорх газар, 7735.9 га нь гэргийн хорооллын газар юм.

Дүрслэл 2.1.1. Улаанбаатар хотын газрын нэгдмэл сангийн өөрчлөлт /1998-2009 он/



Дүрслэл 2.1.2. Хот тосгон, бусад суурин газар

Улаанбаатар хотын газар ашиглалтын өөрчлөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэн 2009 оныг 2000 онтой харьцуулахад хот тосгон бусад суурингийн газар нэмэгдэж, бусад ангиллын газар багасч байгаагийн үндсэн шалтгаан нь газрын харилцааны эрх зүйн өөрчлөлттэй холбоотойгоор газрын нэгдмэл сангийн ангилал өөр хоорондоо



шилжсэн, хүний буруутай үйл ажиллагааны улмаас зарим газрууд тухайн ангиллаас хасагдсан, газар өмчлөлттэй холбоотойгоор газрын эрэлт хэрэгцээ нэмэгдсэн зэрэг болно.

Улаанбаатар хотын тиг гортигт хамрагдах нутаг дэвсгэрийг 2010 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар нь авч үзвэл хөдөө аж ахуйн газар 6116.7 га, 2-дүгээр зурагт үзвэл 41084.5 га, зам шугам сүлжээний газар 844.9 га, ойн сан бүхий газар 703.4 га, улсын тусгай хэрэгцээний газар 8168.7 га байна.

Газар ашиглалтыг 6 дүүрэгт авч үзвэл (Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй) нийт нутаг дэвсгэрийн 69 хувийг эзлэх ба алслагдсан 3 дүүрэгт (Багануур, Багахангай, Налайх) 31 хувь нь ногдоно.

Хүснэгт 2.1.1. Газрын нэгдмэл сангийн ангилал


д-д	Нэгдмэл сангийн ангилал	Газрын хэмжээ /га/		Эзлэх хувь	
		Нийслэл	Улаанбаатар	Нийслэл	Улаанбаатар
1	Хөдөө аж ахуйн газар	265980,1	174732.2	57.0	53.6
2	Бэлчээрийн газар		160480.2		
	Тариалангийн газар		5298.3		
	ХАА-н барилга байгууламжийн		763.1		
3	Хот тосгон бусад суурины газар	41084,5	24174.5	9.0	7.4
4	Барилга байгууламжийн дэвсгэр газар		12455.67		
	Нийтийн эдэлбэр газар		1464.38		
	Үйлдвэрийн газар		1725.93		
	Уурхайн дэвсгэр газар		792.6		
	Гэр сууцны хорооллын газар		7735.9		
5	Зам, шугам сүлжээний газар	5679,0	3942,4	1.0	1.2
6	Авто замын газар		451.5		
	Төмөр замын газар		1128.9		
	Агаарын тээврийн газар		860.0		
	Шугам сүлжээний газар		1502.1		
7	Ойн сан бүхий газар	76966,8	74806.6	16.0	23.1
8	Усны сан бүхий газар	4078,1	3979.1	1.0	1.2
9	Улсын тусгай хэрэгцээний газар	76655.4	43989,6	16.0	13.5
10	Улсын тусгай хамгаалалттай газар		40564,0		
	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар		3358,2 га		
	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар		20,5 га		
	ШУ, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдал байнгын ажиглалтын талбай		46,9 га		
7.	Нийт	470'444	325,660	100.0	100.0

Нийслэлийн 2009 оны газрын нэгдмэл сангийн тайлан

Хүснэгт 2.1.2.. Нийслэлийн дүүргүүдийн нутаг дэвсгэр

д/д	Дүүргийн нэр	Нутаг дэвсгэр /га/
1.	Баянгол	2,949
2.	Баянзүрх	124,412
3.	Сонгинохайрхан	120,063
4.	Сүхбаатар	20,840
5.	Хан-Уул	48,466
6.	Чингэлтэй	8,930
	Улаанбаатар хот нийт:	325,660
7.	Багануур	62,020
8.	Багахангай	14,000
9.	Налайх	68,764

Дүрслэл 2.1.3.. Дүүргүүдийн нутаг дэвсгэрийн эзлэх хувь



Хүснэгт 2.1.3. Нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2000- 2009 оны тайлан /Өөрчлөлт/

Ангилал	2000 он	2001 он	2002он	2003он	2004он	2005он	2006 он	2007он	2008 он	2009 он
Нийслэлийн газар нутаг, бүгд	470444	470444	470444	470444	470444	470444	470444	470444	470444	470444
Хөдөө аж ахуйн газар	324725	324725	324490	279922.1	279654	278760.4	278077.4	274478.1	271011.3	265980.1

Хот тосгон, бусад суурин газар	21684.3	25808.9	26051.9	27776.7	28038.5	28892.6	29529.9	33115.9	36131.6	41084.5
Зам, шугам, сүлжээний газар	9063.7	4939.1	4941.1	5652.2	5652.2	5652.2	5659.6	5668.3	5669.9	5679.1
Ойн сан бүхий газар	110629	110629	110629	76294	76300.3	76339.8	76378.1	76382.7	76891.3	76966.8
Усны сан бүхий газар	4332	4332	4332	4143	4143	4143	4143	4143	4083.9	4078.1
Нөөц газар	10	10	-	-	-	-	-	-	-	-
Улсын тусгай хамгаалалттай газар	-	-	-	76656	76656	76656	76656	76656	76656	76655.4

Эх сурвалж: Нийслэлийн статистикийн эмхтгэл

2000-2009 онд нийслэлийн нутаг дэвсгэрийн газрын нэгдмэл сангийн ангиллын Хот, тосгон бусад суурины газар 19400.2 га-гаар нэмэгдсэн нь бусад ангиллын газар тухайлбал ХАА-н газар 58745 га, Зам, шугам сүлжээний газар 3184.6 га, Ойн сан бүхий газар 33622.2 га, Усан сан бүхий газар 253.9 га-гаар тус тус багассаны үндсэн нөхцөл болж байна.

Хүснэгт 2.1.4. Нийслэлийн газрын нэгдмэл сангийн өөрчлөлт-2008- 2009 он /га/

д/д	Үндсэн ангилал	2008 он	2009 он	Өөрчлөлт
1	ХАА-н газар	271011.14	265980.1	-5031.04
2	Хот тосгон бусад суурины газар	46036.86	41084.5	+4952.36 (4367.92)
3	Зам шугам сүлжээний газар	5688.04	5679	+9.04
4	Ойн сан бүхий газар	77041.95	76966.8	+75.15
5	Усан сан бүхий газар	NA	4078.1	-
6	Улсын тусгай хэрэгцээний газар	NA	76655.4	-

Эх сурвалж: Газрын нэгдмэл сангийн тайлан

2009 оны нийслэлийн нутаг дэвсгэрийн газрын нэгдмэл санг, 2008 онтой харьцуулахад Хөдөө аж ахуйн 5031.04 га-аар, Хот тосгон бусад суурины газар 4952.36 га-аар, Зам, шугам сүлжээний газар 9.04 га-аар, Ойн сан бүхий газар 75.15 га-гаар тус тус нэмэгдсэн байна.

2.2. Газрын төлөв байдал, чанар


Улаанбаатар хотын хүн ам 1 саяыг давж, барилгажсан хэсэгт амьдрах өрхийн тоо 273182 байгаа нь газрын төлөв байдал, чанарт сөргөөр нөлөөлж байна. 2010 оны газрын нэгдмэл сангийн тайлангаас харвал нийт 5694.12 га газар ямар нэгэн хэмжээгээр төлөв байдал, чанарын өөрчлөлтөнд орсны 29 га нь тариалангийн газар, 5587.2 га нь бэлчээр, 23.5 га нь хот тосгон бусад суурины газар, 16.4 га нь ойн сан бүхий газар, 5.0 га нь усан сан бүхий байна. Эдгээрээс 33.0 га нь янз бүрийн шалтгаанаар ухагдаж унаган төрхөө бүрмөсөн алджээ. Хот тосгон бусад суурины газрын чанарын өөрчлөлтийн эх үүсвэр нь ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын бохирдол байна.

2.3. Газрын үнэлгээ, төлбөрийн систем

1995 онд Монгол Улсад газрын үнэлгээ төлбөр тогтоох эрх зүйн орчин бүрэлдэн бий болж газар эзэмшигч, ашиглагч иргэн аж ахуйн нэгж хуулиар тогтоосон хэмжээнд төлбөр төлж байна. Нийслэлийн газрын суурь үнийг Засгийн газраас бүсийн ялгавартайгаар 40-440 сая төгрөгөөр тогтоосон ба Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2005 оны 4/21 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан 2010 оны 7 сарын 16-ны өдрийн 5/39 тоот тогтоолоор "Нийслэлийн нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний бүсчлэл, төлбөр тогтоогуулах

хэмжээг түр тогтоох тухай” тогтоолоор итгэлцүүр, хувь хэмжээг өөрчлөн 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж байна. Газрын төлбөрийн орлого нь нийслэлийн төсвийн орлогод 2010 онд 18 т.төг төвлөрүүлсэн нь 2001 оноос бараг 9 дахин их юм.

Дүрслэл 2.3.1. Нийслэлийн газрын төлбөр тогтооход хэрэглэх бүсчлэлийн хил хязгаар



Хүснэгт 2.3.1. Газрын төлбөрийн орлого

д/д	Он	төлөвлөгөө /сая төг/	гүйцэтгэл /сая төг/	Биелэлт /хувь/
1.	2001 он	1962,9	2053,0	104,6
2.	2002 он	2797,5	3007,0	107,5
3.	2003 он	3257,9	3542,9	108,7
4.	2004 он	3600,0	3765,8	104,6
5.	2005 он	5700,0	5705,2	100,1
6.	2006 он	6585,0	6904,5	104,9
7.	2007 он	11201,0	11290,7	100,8
8.	2008 он	15201,0	15838,0	104,2
9.	2009 он	17180,0	17742,9	103,3
10.	2010 он	17997,5	18013,1	100,1

Хүснэгт 2.3.2. Газрын үнэлгээний бүсчлэл ба төлбөрийн итгэлцүүр, хэмжээ

Д/ д	Газар эзэмшилт, ашиглалтын зориулалт	1-р бүс		2-р бүс		3-р бүс	4-р бүс		5-р бүс		
		1 га газрын суурь үнэ 440.0 сая төгрөг						1 га газрын суурь үнэ 40 сая төгрөг			
		Итгэл цүүр	1м2 газрын үнэ	Итгэл цүүр	1м2 газрын үнэ	Итгэл цүүр	1м2 газрын үнэ	Итгэл цүүр	1м2 газрын үнэ	Итгэл цүүр	1м2 газрын үнэ
1	Иргэний ахуйн зориулалт	0.2	66	0.1	53	0.1	44	0.3	12	0.2	8
2	Төсөвт байгууллага /зөвхөн албан хэрэгцээний/	0.2	88	0.15	68	0.1	44	0.4	16	0.3	12
3	Худалдаа бүх	1	440	0.6	264	0.3	132	1	40	0.5	20

4	төрлийн үйлчилгээ Аж ахуйн үйл ажиллагаа /худалдаа, үйлчилгээнээс бусад/	0.8	352	0.5	220	0.2	88	0.8	32	0.4	16
5	Агуулах, шатахуун түгээх станц, бөөний худалдааны зах, төвүүд	1	440	1	440	1	440	1	40	1	40
6	Бүх төрлийн гарааж /газар дээрх, доорх/	1	440	1	440	1	440	1	40	1	40
7	Хотын нийтийн тээвэр	0.2	88	0.15	66	0.1	44	0.5	20	0.4	16
8	Дулаан, холбоо, эрчим хүч	0.6	264	0.3	132	0.2	88	0.7	28	0.5	20
9	Төмөр зам, нисэх онгоцны буудал а. Барилга байгууламж б. Хамгаалалтын бүс	0.6	264	0.4	176	0.3	132	0.8	32	0.6	24
10	Нам, төрийн бүс байгууллага, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газар	0.3	132	0.2	88	0.1	44	0.8	32	0.4	16
11	Шашин, сүм хийд	0.8	352	0.6	264	0.4	176	0.7	28	0.6	24
12	Бүх төрлийн үйлдвэрлэл /хөдөө аж ахуйгаас бусад/	0.6	264	0.4	176	0.1	44	0.4	16	0.2	8
13	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	0.4	176	0.15	68	0.1	44	0.4	16	0.2	8
14	Хотын захын дүүргүүдэд шинээр үйлдвэрлэл /5 жил/	-	-	-	-	-	-	0.1	4	0.1	4
15	Уурхайн эдэлбэр газар а. Олборлолт хийж буй б. Үйлдвэрлэл	-	-	-	-	-	-	0.8	32	0.8	32
		-	-	-	-	-	-	0.5	20	0.5	20

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 7-р сарын 16-ны өдрийн 5/39 тоот тогтоолын хавсралт 3

2.4. Газрын харилцаа

Улаанбаатар хотын хөгжлийн 2020 ерөнхий төлөвлөгөө батлагдсанаас хойших хугацаанд газрын харилцааны эрх зүйн зохицуулалт улам бүр нарийсч газрыг иргэдэд өмчлүүлснээр төрийн ба хувийн өмчийн газар бий болсон нь төлөвлөлтийн арга ба зарчмыг үндсээр нь өөрчлөхөд хүргээд байна.

Нийт **470444** га газрын 18% буюу 89303,57 га нь **142077** *ёддүй, аа адооёй í үæ, о' деёй* байгууллага, гадаадын иргэн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлд байна.

Хүснэгт 2.4.1. Нийслэлийн Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын судалгаа

№	Зориулалт	Талбай/га/	Хуулийн этгээд	Хувь
1	Иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн	4367.92	78452	5%
2	Иргэний гэр хорооллын болон аж ахуйн зориулалттай эзэмшилд	9183.9831	55556	10%
	Үүнээс: гэр хорооллын зориулалтаар	4752.1		


3	Төрийн байгууллагын эзэмшилд	10762.15	836	12%
4	Аж ахуйн нэгжийн эзэмшилд	18800.85	6954	21%
5	Бусдын эзэмшиж буй газрыг ашиглагч Монгол улсын аж ахуйн нэгжийн	882.4	37	1%
6	Гадаадын иргэн болон харьяалалгүй хүний ашгигчид	31.15	47	1%
7	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын бусад иргэд	779.15	194	
8	Хөдөө аж ахуйн эзэмшил, ашиглалтанд	6116.66		7%
9	Хот тосгон бусад суурины газрын эзэмшил, ашиглалтанд	28653.37		32%
10	Зам тээврийн хэрэгсэл, ашиглалтанд	844.91		1%
11	Ойн сан бүхий газрын эзэмшил, ашиглалтанд	703.36		1%
12	Улсын тусгай хэрэгцээний газрын эзэмшил, ашиглалтанд	8168.77		9%
Нийт		89303.57	142077	

Нийт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, хөдөө аж ахуйн эзэмшил, хот тосгон бусад суурины газрын эзэмшил, ашиглалтанд, зам тээврийн хэрэгсэл, ашиглалтанд, ойн сан бүхий газрын эзэмшил, ашиглалтанд, улсын тусгай хэрэгцээний газрын эзэмшил, ашиглалтанд нийт 89303.57 га, 142077 хувьцаа, 12% нь төрийн байгууллагын эзэмшилд, 21% нь аж ахуйн нэгжийн эзэмшилд, 1% нь бусдын эзэмшиж буй газрыг ашиглагч Монгол улсын аж ахуйн нэгжийн, 1% нь гадаадын иргэн болон харьяалалгүй хүний ашгигчид, 7% нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын бусад иргэд, 32% нь хот тосгон бусад суурины газрын эзэмшил, ашиглалтанд, 1% нь зам тээврийн хэрэгсэл, ашиглалтанд, 1% нь ойн сан бүхий газрын эзэмшил, ашиглалтанд, 9% нь улсын тусгай хэрэгцээний газрын эзэмшил, ашиглалтанд байна.

2009 онд газраа өмчилсөн өрхийн тоо 80,203 байна. Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн эдэлбэр газрын (29,529.87 га) 9,9 % буюу нийт 9 дүүргийн эдэлбэр газрын (470,444.00 га) 0,6 %-ийг иргэдийн хувьд өмчлөгдсөн газар (4367.92 га) эзэлж байна.

Газрыг ашиглалтын зориулалтаар ангилан үзэхэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 80203 иргэнд өмчлүүлсэн 4367.9 га, аж ахуйн зориулалтаар иргэдийн эзэмшилд 9184.0 га, тус тусад нь гадаадын иргэн болон харьяалалгүй хүний ашиглалтанд, 779.1551 га нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн ашиглалтанд тус тус байна. Ерөнхийдөө нийслэлд 44487.1 га газар эдийн засгийн идэвхтэй эргэлтэнд оржээ.

Дүрслэл 2.4.1. Газар ашиглалтын эрхзүйн судалгаа



Эх сурвалж: Нийслэлийн газрын нэгдмэл сангийн тайлан 2009 он


III БҮЛЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГАЖИЛТ

3.1. Улаанбаатарын бүсийн хөгжил

Монгол улсын Их Хурлын 2001 оны 57-р тогтоолоор батлагдсан Монгол орны бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол улсын нутаг дэвсгэрийг эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр тусгасан. Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, эдийн засаг, нийгэм, оюуны чадавхийг харгалзан хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоосон.


Дүрслэл 3.1.1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

Эдийн засгийн муж



Хөгжүүлэх үзэл баримтлал нь улмаар хотын хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв, байдал, нийгмийн харилцааны гол төв, цомхон хот болгон хөгжүүлэх зорилгыг агуулсан.


Дүрслэл 3.1.2. Ази Европын дэд бүтцийн сүлжээнд холбогдох чиглэл



Хөгжүүлэх үзэл баримтлал нь улмаар хотын хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв, байдал, нийгмийн харилцааны гол төв, цомхон хот болгон хөгжүүлэх зорилгыг агуулсан.


Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс буюу Төв аймгийг Төвийн бүсэд, Нийслэлийн нутаг дэвсгэрийг Улаанбаатарын бүсэд хамруулсан байна. Төвийн бүс нутаг бүрэлдэх гол хүчин зүйл бол Улаанбаатар хот болон Европ, Азийг холбосон олон улсын төмөр зам, төвийн эрчим хүчний систем, авто замын үндсэн тэнхлэг, төмөр замын дагуу байрлаж

Дүрслэл 3.1.3. Төв аймгийн нутагшил суурьшлын тогтолцоо



буй хотууд, тэдгээрийн нийгмийн болон инженерийн дэд бүтэц, эдийн засгийн чадавх болно. 2000 онд “Хүн амын нутагшилт, суурьшил, бүсчилсэн хөгжлийн ерөнхий төсөл”-ийг Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар баяжуулан тодотгож нэгтгэн авч үзсэн боловч засаг захиргааны хувьд татагдах гол, гол чиглэлүүдийг илүүтэйгээр авч үзэн зам тээврийн зангилаа, уул уурхай, үйлдвэрлэлийн төрөлжилтөд түшиглэн цаашид хөгжих бичил бүсүүдийн үүргийг харгалзаагүй байна. Төвийн бүсийн хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоог авч үзэхдээ Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүсийг Төв аймгийн хилээр тогтоож болох боломжтойг харуулан Төв аймгийн бүх сумдыг Улаанбаатар хот руу шууд татагдах чиглэлтэйгээр авч үзэн тус бүсэд үүсч болох бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоог тооцож тусгаагүй.

Дүрслэл 3.1.4. Төвийн бүсийн нутагшил суурьшлын тогтолцоо



Төвийн бүс нутаг нь: Ази – Европыг холбосон авто болон төмөр замын тэнхлэгт татагдан хөгжсөн нэгдмэл нэг нутаг дэвсгэрийн систем учир Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс буюу Төв аймгийн нутагшил, суурьшилтын тогтолцоо, хөгжлийн хэтийн төлөвийг Төвийн бүс болон Улаанбаатарын бүсийн хөгжлийн чиг хандлагатай нягт уялдуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Дархан-Сэлэнгийн газар тариалан, аж үйлдвэрийн бүс,
2. Нийслэл Улаанбаатар хотын эрчимтэй таталцал нөлөөллийн бүс,
3. Говийн уул уурхай, аж үйлдвэр, байгаль хамгаалах бүс эдгээр болно.

Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр” /2006-2015 он/-ийг 2006 онд Монгол улсын Засгийн газрын 197 тоот тогтоолоор баталсан. Хөтөлбөрт Улаанбаатар бүсийн өмнө тулгарч буй асуудлуудыг дэс дараатай шийдвэрлэх, бүсийн хүн амын нутагшилт, суурьшлын

- Улаанбаатар хотын дагуул, хаяа хот тосгодыг түлхүү хөгжүүлж, нутагшилт суурьшлын оновчтой тогтолцоог бий болгох үндэс суурийг тавина.
- Улаанбаатарын бүсийн эрчимтэй таталцал, нөлөөллийн бүсийн түвшинд тулгамдсан нийтлэг асуудлуудыг Төвийн болон Зүүн бүсийн аймгуудтай хамтран шийдвэрлэнэ.
- Улаанбаатарын бүсийн зарим чиг үүргийг Монгол улсын бусад тулгуур төв хотуудад шилжүүлэх үндэс суурийг тавина.
- Улаанбаатарын бүсийн хүн амын нутагшилт суурьшлын оновчтой тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдүгээр үе шат 2010 онд дууссан ба биелэлт хангалтгүй, явц удаашралтай, тулгамдсан асуудлууд хуримтлагдсаар байгаа нь улс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт, хот байгуулалтын бодлогын харилцан уялдаа хангалтгүй хөгжлийн бодлогыг орон зайн хэмжээнд авч үзэж, бүсүүдийн тулгуур төв хотуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, харилцан хамааралд тулгуурлан төлөвлөлт хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлж, нийгмийн ямар үйлчилгээг аль хот, тосгодод шилжүүлж хэрхэн хөгжүүлэх төлөвлөлт, хөрөнгө оруулалтын төрийн оновчтой бодлого үгүйлэгдэж байгаатай шууд холбоотой болно.

[illegible]

НИЙСЛЭЛЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН

боловч бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 60 орчим жижиг суурьшил бий болсон байна.

2009 оны байдлаар 294,00 мянган өрх, 1161,70 мянган хүн амтай байгаа бөгөөд Улаанбаатарын бүсийг 2020 онд 1534 мянган хүнтэй байхаар тооцсон байдаг. Хүн амын нягтрал **246 хүн/км²** байна.

3.1.1. Улаанбаатарын бүсийн дэд бүтцийн хөгжил

Налайх хот дахь эрчим хүчний бие даасан салбар нь Багахангай дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Архустай, Баянжаргалан сумын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарч жилд дунджаар 41200.0 мян.квт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг, эрчим хүчний хүрэлцэхүйц нөөцтэй. Налайх хот Улаанбаатар хотын дээд эх үүсвэрээс хангагдах цэвэр усны шугам нь 1000 м³ усан сантай. Цэвэрлэх байгууламж нь хоногт 1400 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай 2008 онд Улаанбаатар хотын төв шугамтай холбохоор шийдвэрлэж Туул-1 коллектор баригдаж байгаа.

2001 онд Улаанбаатар хот, Налайхын хооронд шилэн кабель татаж 1536 хэрэглэгчийн багтаамж бүхий электрон АТС ашиглалтад оруулснаар дэлхийн олон оронтой шууд харилцах боломжтой болсон. 2003 оноос утасгүй холбооны станц ашиглалтад орж алслагдсан хэсэг, гэр хорооллыг хангасан. Мөн хөдөлгөөнт холбооны Мобиком, Скайтел, Юнителийн үйлчилгээтэй.

Түүнчлэн мянганы замын босоо тэнхлэгийн АН-3, хэвтээ тэнхлэгийн АН-32 дугаарын асфальт болон бетон хучилттай зам Налайх хотыг дайран өнгөрч байна.

Босоо тэнхлэгийн АН-3 замын Алтанбулаг-Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Чойрын 584 км-ийн хатуу хучилттай зам ашиглалтад орсон, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 425 км хатуу хучилттай зам 2013 онд ашиглалтад бүрэн орно.

Улаанбаатар хот, Налайхын хооронд төмөр замтай боловч хүчин чадал бүрэн дүүрэн ашиглагдаж чадахгүй байгаа. Төмөр зам, авто замаар Налайх, Улаанбаатар хотын хооронд хот орчмын зорчигч тээврийн байнгын үйлчилгээ явдаг нь хил залгаа аймаг, сум, орон нутгийн байгууллагууд хангагдана.

Өдгөө Улаанбаатар хот, Налайхын хооронд 20 км хурдны зам, мөн Туул гол дээгүүр 288 метрийн урттай шинэ гүүр АНУ-ын МСС-гийн хөрөнгө оруулалтаар баригдахаар холбогдох ажлууд нь хийгдэж байна. Ерөнхийд нь дүгнэхэд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт олон улсын ачаа тээврийн терминалийг байгуулахад эдэлбэр газар, дэд бүтцийн хангамжийн хувьд хүрэлцээтэй, хөрөнгө оруулалт харьцангуй бага шаардах, орон нутгийн болон олон улсын зам харилцаанд саадгүй холбогдох нөхцөл бүрдэж байгаа нь дээрх мэдээллүүдээс харагдаж байна. Налайх дүүргийн Баян зөрлөгийн ойролцоо шинэ терминал барих судалгааг тээвэр зуучийн Туушин компани, Улаанбаатар хотын захиргаатай хамтран боловсруулж байгаа мэдээлэл байна.

Өлзийт тосгон:

Засаг захиргааны бүтэц: ХУД-ийн 14-р хороо

Газар нутаг, хүн ам, эдийн засаг: 9,6 мянган га нутаг дэвсгэртэй, 3,2 мянган хүн ам, 1,1 мянган өрхтэй. Нийт 11600 орчим малтай. 280 өрх мал аж ахуй эрхэлдэг.

<i>Нийгмийн хангамж:</i>	Сургууль	526 хүүхэд
	Цэцэрлэг	111 хүүхэд

Түүл-шувуу тосгон:

Засаг захиргааны бүтэц: ХУД-ийн 13-р хороо

Газар нутаг, хүн ам, эдийн засаг: 8.0 мянган га нутаг дэвсгэртэй, 3,6 мянган хүн ам 1,2 мянган өрхтэй, томоохон гахай шувууны аж ахуйнууд болох “Коре –Алмаз” ХХК, “Гроватз” ХХК, “Бөхөг” ХХК, “Түмэн шувуут” ХХК, “Халиудай хүү” ХХК, “Б.Агро” ХХК, “Шимт газар” ХХК, “Ногоон зам” ХХК, 8 нэрийн хүнсний дэлгүүр -9, 6 нэрийн хүнсний дэлгүүр -3, шатахуун түгээх станц -2, христийн сүм -2, цайны газар -1 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Тус хороо нь "Дэлхийн Зөн", "Адра" "Тайванийн гэр бүлийг дэмжих сан" "Кристина Нобель"-ийн сан, "Good Hands" хүүхэд залуучуудын төв, дүүргийн "Улаан загалмайн хороо" зэрэг олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулж байна. Агропарк, Багро 70 га газартай.

Нийгмийн хангамж:

Сургууль	500 хүүхэд
Цэцэрлэг	240 хүүхэд

Сонгино-Буокомбинат

Засаг захиргааны бүтэц: ХУД-ийн 12-р хороо

Газар нутаг, хүн ам, эдийн засаг: 0,6 мянган га газартай, 5,7 мянган хүн ам, 1,6 мянган өрхтэй. Нийт 5000 орчим малтай. 172 өрх мал аж ахуй эрхэлдэг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл байхгүй.

Эрхэлж буй үйл ажиллагаа: Амралт сувилал, аялал жуулчлалын газар жилээс жилд нэмэгдэж байгаа. Солонгосын хөрөнгө оруулалттай гольфийн талбай баригдаж эхэлсэн.

- Ахмадын сувилал
- Нялхсын сувилал
- Сонгинын амралт
- Солонгос амралт

Нийгмийн хангамж:

Сургууль	560 хүүхэд
Цэцэрлэг	140 хүүхэд

Жаргалант-Партизан тосгон:

Засаг захиргааны бүтэц: СХД-ийн 21-р хороо

Газар нутаг, хүн ам, эдийн засаг: 64.0 мянган га газартай, 5,8 мянган хүн ам, 1,8 мянган өрхтэй. Гүнтийн аманд 600, нарийний аманд 600, мөн 800 үнээний фермтэй байсан одоо бүгд ашиглагдахгүй байгаа.

Нийгмийн хангамж:

Сургууль	450 хүүхэд
Цэцэрлэг	150 хүүхэд
Дотуур байр	100 хүүхэд

Аргалант-Эмээлт тосгон:

Засаг захиргааны бүтэц: СХД-ийн 32-р хороо, Бордоо, Эмээлт, Баруун туруу, Хурган гэж 4 хэсэгтэй..

Газар нутаг, хүн ам, эдийн засаг: 1,0 мянган хүн ам, 0,2 мянган өрхтэй. Эмээлтэд 100 гаруй аж ахуй үйл ажиллагаа явуулдаг, явуулын болон түрээсийн 600 хүн ажиллаж байна. Сүүний чиглэлийн 2-3 фермертэй.

Тэрэлж: /БЦГазар/

Засаг захиргааны бүтэц: Налайх дүүрэг 6-р хороо, Налайх дүүргийн 1, 5-р хороо, Гачуурт тосгон, Төв аймгийн Эрдэнэ сумтай тус хиллэдэг.

Газар нутаг, хүн ам, эдийн засаг: хотоос 70 км, Налайх дүүргээс 40 км алслагдсан, 30,0 мянган га газар нутагтай, 1,3 мянган хүн ам, 0,6 мянган өрхтэй. Хорооны нутаг дэвсгэрийн ихэнх нь Хан Хэнтийн тусгай хамгаалалттай, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт багтдаг. Аялал жуулчлалын бүсэд 60 гаруй аялал жуулчлалын баазууд, 5 хүүхдийн зуслан, 5 амралтын газар байнгын болон улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг.

Гачуурт тосгон:

Засаг захиргааны бүтэц: БЗД 20-р хороо

Газар нутаг, хүн ам, эдийн засаг. 74,8 мянган га газартай, 6,2 мянган хүн ам, 1,9 мянган өрхтэй. Улсын дархан цаазтай, хамгаалалттай ногоон бүсэд хамаардаг, 45,000 толгой малтай, төсвийн 5, хувийн хэвшлийн 16 байгууллага, аж ахуйн нэгжтэй.


Нийгмийн хангамж: Сургууль 480
Цэцэрлэг 130

Аэросити: Одоогийн байдлаар Төв аймгийн Хөшигийн хөндийд шинээр баригдах олон улсын нисэх онгоцны буудал, түүнийг түшиглэн байгуулагдах хотын ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажил боловсруулагдан бэлэн болж байна. Нисэх буудал, хотыг барьж байгуулах ажил хараахан эхлээгүй, бэлтгэл ажил хийгдэж байна.

3.1.2. Улаанбаатарын бүсийн эдийн засаг, хөдөө аж ахуйн салбарын хөгжил

Дүрслэл 3.1.2.1.

Нийслэлийн малын тоо толгойн өөрчлөлт



Эх сурвалж: УСХ, Статистикийн эмхэтгэл –2002-2010

Улаанбаатарын бүсийн нутаг дэвсгэр нь нийт 470'444.0 га ба үүнээс 278'760.5 га буюу 59 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 28'892.6 га буюу 6 хувийг хот тосгон, суурин газар, 5652.2 га буюу 1.2 хувийг зам, шугам сүлжээний газар, 76'339.8 буюу 16 хувийг ойн сан бүхий газар, 4143.0 га буюу 1 хувийг усан сан бүхий газар, 76656.0 га буюу 16 хувийг улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна. 470 мянган га нутаг дэвсгэртэй Улаанбаатар хотын эдийн засагт үзүүлэх ХАА-н

салбарын нөлөө тун ялихгүй 2002-2010 онд үйлдвэрийн бүтээмж 7.2 дахин нэмэгдэж 2010 онд 36 тэрбум төгрөгний үйлдвэрлэл эрхэлсэн нь ДНБ-д том нөлөө үзүүлж чадаагүй, хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь хөгжлийн хэтийн төлөвийн томоохон зорилтот асуудал болж байна.

Улаанбаатар хот нь өөрийн хэрэгцээнд үйлдвэрлэгддэг бага хэмжээний хүнсний ногоо, МАА-н тэжээлийн тариалалтыг хийхдээ эдэлбэр газраасаа ердөө 1134.3 га-г нь ашиглаж байна. Энэ нь 2000 оныхоос бараг 2 дахин буурсан үзүүлт юм.

Нийслэлийн МАА-н салбар нь 2010 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт 262881 толгой мал тоологдсон нь 2009 оноос 34.4 хувиар буюу 137944 толгой малаар буурсан байна. Монгол улсын хэмжээнд 2010 онд 32.7 сая толгой мал тоологдсон бөгөөд нийслэлийн мал 0.8 хувийг эзэлж байна.

Нийт тариалсан талбай бүх жилүүдийн хувьд бараг өөрчлөлтгүй буюу 1134 га байгаа нь нийслэлийн нутаг дэвсгэр тариалалт хийх газрын нөөц багатай байгаагаар тайлбарлагдана. Нийслэлийн тариалалтын талбайд нь ихэвчлэн төмс, хүнсний ногоо тариалагддаг бөгөөд нийт шаардлагатай байгаа төмсний 91,1 хувийг, хүнсний ногооны 97,5 хувийг тус тус импорт, бусад бүсээс хангаж байна. 1га –аас авсан ургацын хэмжээг харахад сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. 2010 оны байдлаар нийслэл нь өөрийн тариалангийн бүс нутгаасаа 5297.5 ын төмс, 3014.4 тн хүнсний

ногоогоор хангаж төмсний хэрэгцээний 9.5 хувь, ногооны хэрэгцээний 9.4 хувийг хангажээ.

Хүснэгт 3.1.2.1. ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлт /2010 оны байдлаар/

Нийлүүлэлт	Тоо хэмжээ				Эзлэх хувь			
	УБ	Бусад	Импорт	Нийт	УБ	Бусад	Импорт	Нийт
Нэр төрөл								
Мах, махан бүтээгдэхүүн	920	91,092		92,012	1%	99%		100%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	33,800	26,030	28,000	87,830	38%	30%	31.9%	100.0%
Гурил, гурилан бүтээгдэхүүн	147,000	712	65	147,777	99%	0.5%	0.0%	100.0%
Будаа			23,700	23,700	0%	0%	100.0%	100.0%
Сахар, чихрийн зүйл			19,518	19,518	0%	0%	100.0%	100.0%
Төмс	5,298	53,208	9	58,514	9.1%	90.9%	0.0%	100.0%
Хүнсний ногоо	3,014	28,985	65	36,223	8.3%	80.0%	0.2%	100%
Жимс, жимсгэнэ		869	8,890	9,759	0.0%	8.9%	91.1%	100%
Өндөг	48		9	57	84%	0%	16.0%	100.0%
Мал, ургамлын гараглтай тос		971	6,000	6,971	0.0%	13.9%	86.1%	100%

Улаанбаатар хотын хүн амын механик өсөлт, хэт төвлөрлөөс үүсэлтэй олон асуудал бий болсны нэг нь хүн амын хүнсний бүтээгдэхүүний үнийн тухай асуудал юм. 2002 оныг суурь болгосон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнийн хөдөлгөөнийг харахад 2002 оноос хойш дунджаар гурил, гурилан бүтээгдэхүүн 220 хувиар, мах, махан бүтээгдэхүүн 360 хувиар, сүү сүүн бүтээгдэхүүн 230 хувиар, төмс, хүнсний ногоо 220 хувиар тус тус өссөн байна. Харин 2005 оныг суурь болгосон үнийн өсөлтийг харахад гурил, гурилан бүтээгдэхүүн 175 хувиар, мах, махан бүтээгдэхүүн 180 хувиар, сүү сүүн бүтээгдэхүүн 215 хувиар, төмс хүнсний ногоо 180 хувиар өссөн бөгөөд энэ нь 2007 оноос хойш үнийн өсөлт эрчимжсэн байгааг харуулж байна.

Нийслэл нь мах, махан бүтээгдэхүүнийхээ 1 орчим хувийг, сүү сүүн бүтээгдэхүүнийхээ 38 хувийг, төмс хүнсний ногооныхоо 9 хувийг, гурил гурилан бүтээгдэхүүнийхээ 99 хувийг, сүү сүүн бүтээгдэхүүнийхээ 80 хувийг бүсийнхээ үйлдвэрлэлээс хангаж байгаа нь чамлалтай бөгөөд хотын хаяа хот, тосгод, ХАА-г хөгжүүлэх бүсийн нутаг дэвсгэрт эрчимжсэн МАА, фермерийн АА-г тууштай хөгжүүлж зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулж үнийн хэт өсөлтийг бууруулах, нөгөө талаас ажлын байр өрхийн амьжиргааг дээшлүүлэх, импортын зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 100 хувь дотооддоо хангах боломжийг бий болгох боломжтой.

Бэлчээрийн даац, ачаалал: Нийслэлийн орчимд 263 мянган мал байгаагийн 90% нь бэлчээрийн мал учраас бэлчээрийн хөрсийг ихээхэн талхалж байна. Хот орчмын ногоон бүсийн бэлчээрийн даац 5,8 дахин хэтэрч, өвслөг ургамалтай газрын 47,8% буюу 151,0 мян.га газар хүчтэй талхлагдсан байна.

Нийслэл хот нь өөрийн ХАА-н эдэлбэр газартаа бэлчээрийн мал аж ахуйгаар хонин толгойд шилжүүлснээр хамгийн ихдээ 390 мянган толгой малыг багтаах чадвартай боловч 2000 онд хонин толгойд шилжүүлснээр 568 мянга, 2005 онд 572 мянга, 2010 онд 633 мянга байлаа.


Эндээс нийслэл хотын бэлчээрийн даац хэтрээд тун удаж байгааг харж болох юм. 2000 оны байдлаар 146 хувийн хэтрэлттэй байсан даац, 2005 онд 147 хувийн илүүдэлтэй байсан ба харин 2010 оны байдлаар 162 хувь болж өссөн байна.

Сүүлийн жилүүдэд эрчимжсэн МАА, ФАА-г хөгжүүлэх чиглэлээр олон ажил хийгдэж байгаагийн нөлөөгөөр нийслэл хотод гахайн, тахианы аж ахуйн тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.

Нийслэлд гахайн тоо толгой 2010 онд 2000 онтой харьцуулахад нийслэл хот дах гахайн тоо толгой 9,7 дахин нэмэгдсэн бол 2005 онтой харьцуулахад 2 дахин нэмэгджээ. Харин тахианы тоо 2010 онд 2000 онтой харьцуулахад 3,7 дахин нэмэгдсэн байна.

Улаанбаатар бүсийн хэмжээнд ХАА-г эрчимтэй хөгжүүлэх бүс, нутаг дэвсгэрийн зохистой тогтолцоо бүрдээгүй, газар ашиглалтын эмх замбараагүй байдал нь байгалийн голомтот халдварт өвчин сүрьеэ, бруцеллөз, боом, галзуу, сальмонеллөз, цусан халдвар, гахайн мялзан, хонины цэцэг гэх мэт өвчний голомт 2007-2009 онд Улаанбаатар хот орчмын зарим аж ахуй, мал бүхий иргэдийн суурьт илэрч эдийн засгийн ихээхэн хохирол учруулснаас гадна хүн амын хүнсний хангамжаар дамжин халдвар тархах эрсдэлийг нэмэгдүүлж байгааг онцгой анхаарч төлөвлөх шаардлагатай.

Дүрслэл 3.1.2.2. Нийслэлийн бэлчээрийн даац 2000-2010 онд¹



Эх сурвалж: ХАА-н багийн тооцоолсноор

Монгол улсын бусад бүс нутагт сүүний илүүдэлтэй байхад Улаанбаатар хотод сүүний дутагдлаа импортоор нөхөж байгаа нь дотоодод үйлдвэрлэгдсэн сүүг үйлдвэрт нийлүүлэх бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо алдагдсантай холбоотойгоор манай томоохон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн түүхий эдэд импортын хуурай сүү зонхилох байр суурийг эзэлсээр байна.

3.2. Улаанбаатар хотын хүн амын суурьшилт, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт

Түүхэн хөгжлийн явцад Улаанбаатар хот, хот байгуулалтын 5 ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжиж хүн амын суурьшилт, нутаг дэвсгэр зохион байгуулалтын одоогийн тогтолцоог бүрдүүлжээ. Улаанбаатар хотын анхны ерөнхий төлөвлөгөөг 1954 онд /62000 хүн/ 20 жилийн хугацаатай төлөвлөж 125000 хүн амтай байхаар тооцсон.

Хоёр дах ерөнхий төлөвлөгөөг 1961 онд боловсруулахдаа 20-25 жилийн дараа 1981-1986 онд 230-250 мянган хүн амтай байхаар тооцож 3900 га талбайг барилгажуулахдаа суурьшлын бүс нь, үйлдвэр, аж ахуйн бүсээс тусдаа байхын зэрэгцээ орон сууцны 19 хороолол барихаар төлөвлөсөн.

¹ Хонин толгойд шилжүүлэх итгэлцүүрээр, болон даацын стандартаар тооцооллоо


Дүрслэл 3.2.1. Нийслэл хүрээ 1911 он.
/1163.0 га/



Дүрслэл 3.2.2. Улаанбаатар хот 1944 он.
/2827.0 га/



Дүрслэл 3.2.3. Улаанбаатар хот 1952 он
/3375.0 га /



Дүрслэл 3.2.4. Анхдугаар ерөнхий төлөвлөгөө
1954 î î
Төлөвлөлтийн хүн ам - 125.0 мян.хүн




Дүрслэл 3.2.5
Улаанбаатар хот 1961 он / 4252 га /




Дүрслэл 3.2.6.
II ерөнхий төлөвлөгөө - 1963 î î
Төлөвлөлтийн хүн ам - 250 мян.хүн



Дүрслэл 3.2.7.
Улаанбаатар хот 1974 он / 8133 га /



Дүрслэл 3.2.8.
III ерөнхий төлөвлөгөө - 1975 î î
Төлөвлөлтийн хүн ам - 600 мян.хүн



Гурав дах ерөнхий төлөвлөгөөг 1975 онд боловсруулахдаа 25 жилийн хугацаанд 2000 онд 400 мянган хүн амтай байхаар хүн амын өсөлтийг хязгаарлан тооцож, хотыг үндсэн 3 том район, орон сууцны 21 хороололд хувааж төлөвлөсөн.

Дөрөвдүгээр ерөнхий төлөвлөгөөг 1986 онд боловсруулахдаа 20 жилийн хугацаанд хүн амын механик өсөлтийг 2010 он гэхэд бүрэн хязгаарлах зарчмаар Улаанбаатар хотод 850.0 мянган хүн, дагуул хотод 100.0 мянган хүн оршин сууна гэж үзсэн. Хотын бүтцэд гарах шинэ үүргүүдийг алслагдсан суурингуудад шилжүүлэх, бүлэг суурьшлын системийг бүрдүүлэх зорилт тавьсан нь бүсчлэн хөгжүүлэх бодлогын суурь болсон байдаг. Хот орчмын бүлэг суурин бүхий бичил бүс нь харьцангуй байгалийн унаган төрхөө хадгалсан уул, ус, гол горхи бүхий эко-систем хотын оршин суугчдын амралт, алжаал тайлах орчин байна гэж үзсэн байна.

Дүрслэл 3.2.9.

Улаанбаатар хот 1986он / 9864 га /



Дүрслэл 3.2.10.


IV ерөнхий төлөвлөгөө - 1986 î î

Төлөвлөлтийн хүн ам - 850,0 мян.хүн



Гурав дах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан орон сууцны 21 хорооллыг 29 болгон нэмэгдүүлж газар нутгийн багтаамжийг оновчтой тооцоолон барилгажилт явуулах хангалттай нөөц бий болгосон зэрэг эерэг төсөөллүүд байсан ч удаа дараагийн ерөнхий төлөвлөгөөнд “гэргүй” байхаар тооцож гэр сууцыг орхигдуулсан нь хүн амын амьжиргааны хоёр өөр нөхцөлийг бий болгон өнөөгийн тулгамдсан асуудлуудын эх үүсвэр болсон байна.

Дүрслэл 3.2.11. **Улаанбаатар хот 1998 он /16650.0 га/**




Хотын өсөлтийг хязгаарлах үүднээс суурьшлын бүлэг системүүдийн төвүүдийг ажлын байртай нь хамгийн дөт замаар холбох, хүн амын амьдрах орчны нэгдсэн системийг байгалийн болон эрүүл ахуйн хамгийн тохиромжтой нөхцөлөөр хангах, суурьшлын

бүсэд хортой үйлдвэр, онцгой объектуудыг байрлуулахыг хориглох, шинэ технологи нэвтрүүлэх замаар мал тууврын зам, талбайг багасгах зарчмыг дэвшүүлсэн байдаг.

Тав дах ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа 2002 онд 20 жилийн хугацаанд нийслэлийн хүн ам 1.65 сая, үүнээс Улаанбаатар хот 1.15 сая, хүн амын нягтрал 180 хүн/га болно гэж тооцсон. 2010 онд нийслэл 1.135 сая, Улаанбаатар хот 1.0 сая хүн амтай байхаар тооцон төлөвлөсөн байна.

Улаанбаатар бүсэд 2009 оны байдлаар 1067472 хүн байнга оршин сууж байгаа нь Монгол улсын хүн амын 40.5%-тай тэнцэж байна. Нийслэлийн хүн ам 2000 онд 760077 байсан бол 2009 онд 1067472 болж өсчээ. 2000 онд нийслэлийн нэг км² нутаг дэвсгэрт 162 хүн оршин сууж байсан бол 2009 онд 246 хүн/км² болж 2000-2009 онд хүн амын нягтрал 45.1%-иар өсчээ.

Дүрслэл 3.2.12. V ерөнхий төлөвлөгөө 2002 он



Монгол улсын хүн амын суурьшлыг бүс нутгаар ангилж үзэхэд нийт хүн амын ихэнх буюу 43,6 хувь нь Улаанбаатар хотод, хамгийн бага буюу 7.0 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байгааг хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор тогтоосон байна.

3.2.1. Түүх, соёл, археологийн дурсгал

Улаанбаатар хотод байгаа түүх, соёлын дурсгалт байшин барилга:

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5-р сарын 14-ний өдрийн 175 дугаар тоот тогтоолоор Монгол Улсын “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг 4 дэх удаагаа шинэчлэн баталсан билээ. Энэхүү жагсаалтад Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Улсын болон нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал хэмээн он цаг, ач холбогдол, онцлог, дахин давтагдашгүй гэх мэт үзүүлэлтүүдийг харгалзан хоёр хуваан авч үзсэн байдаг. Үүнд:

- Улсын хамгаалтад байх түүх, соёлын үл хөдлөх 14 дурсгал
- Нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын 11 дурсгал багтсан байна.

Улсын хамгаалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд:

1. Ардын намын Төв хороо, Ардын түр засгийн газар түр байрлаж байсан байшин
2. Анхны “Өндөр хоршоо”-ны 2 давхар байшин
3. Алтан-Өлгий дэх оршуулгын газар
4. Богд хааны ногоон ордон музейн цогцолбор

5. Гандантэгчинлэн хийдийн цогцолбор
6. Гачууртын амны хадны зураг
7. Гэр хэлбэрт модон дугануудын цогцолбор
8. Гэсэр сүмийн цогцолбор
9. Дамбадаржаа хийдийн цогцолбор
10. Дарь-Эхийн сүмийн 2 ширхэг чулуун багана, Гол сүм
11. Их тэнгэрийн амны хадны зураг
12. Сонгинохайрхан уулын булшнууд
13. Сонгинохайрхан уулын өвөрт орших Тоорил ханы ордон хэмээн нэрлэдэг ордны туурь
14. Чойжин ламын сүм музейн цогцолбор


Нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалууд:

1. Анхны европ хоёр давхар байшин
2. Анхны холбооны байшин
3. Сэлбэ голын гүүрний хоёр ширхэг чулуун арслан
4. Байгалийн түүхийн музейн өмнөх хоёр ширхэг чулуун арслан
5. Богд хааны зуны ордны зарим барилга
6. Бэлхийн амны Хүннүгийн үеийн булшнууд
7. Зүүн хүрээний нууц бүлгэм байрлаж байсан байшин
8. Консулын дэнжийн нууц бүлгэм байрлаж байсан байшин
9. Монгол Улсын их сургуулийн хичээлийн I байрны өмнөх хоёр ширхэг чулуун арслан
10. Монгол Улсын Ерөнхий сайд П.Гэндэнгийн амьдарч байсан байшин
11. Д.Сүхбаатар жанжны анхны хөшөө зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд Туул голын орчимд бэлчдэг, түүнээс ундаалдаг мал, амьтанд Эндемик өвчин болох орингот, саажих, хээлийн хүндрэл үзүүлэх, булчин цайх, малын үс унах, хэт давжаа төл гарах, төрөлтийн гажиг үүсэх зэрэг орон нутгийн олдмол шинж тэмдэг бүхий өвчнүүд шинээр үүсч байгаа нь Туул голын ус хром болон бусад химийн бодисоор бохирдсонтой холбоотой болох нь тогтоогдсон байна.

Дүрслэл 3.6.1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэл




Цаашид мал, амьтны гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос гаргаж орон нутагт нь боловсруулах асуудлыг бүсүүдийн хөгжлийн хүрээнд авч үзэж нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.

IV БҮЛЭГ. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

4.1. Эдийн засгийн хөгжил

Монгол Улсын эдийн засагт нийслэл Улаанбаатар хотын гүйцэтгэж буй үүрэг жилээс жилд улам бүр өссөөр байна. Энэ нь Монгол Улсын ДНБ-ний үйлдвэрлэлийн болон нийслэл Улаанбаатар хотын ДНБ-ний үйлдвэрлэлийн хоорондын харьцаанаас тодорхой харагдаж байгаа юм. Жишээлбэл, нийслэл Улаанбаатар хот 2007 онд манай улсын ДНБ-ний 46.9 хувийг үйлдвэрлэж байсан бол 2008 онд 50,6 хувийг, 2009 онд 59,4 хувийг, 2010 онд 62,7 хувийг тус тус үйлдвэрлэжээ

Дүрслэл 4.1.1. Монгол Улсын бүс нутаг, аймгуудын ДНБ-ний болон нийслэл Улаанбаатар хотын ДНБ-ний хоорондын харьцаа



Дээр дурдсанаас үзэхэд өнөөгийн байдлаар манай улсын ДНБ-ний 60 гаруй хувийг нийслэл Улаанбаатар хотод үйлдвэрлэж, нийслэл хотоос буюу нэг хотоос улс орны эдийн засаг хэт хамааралтай байна. Гэтэл БНХАУ-ын ДНБ-ний 4.4 хувь Бээжин хотод, Япон улсын ДНБ-ний 26.2 хувь Токио хотод, ОХУ-ын ДНБ-ний 23.7 хувь Москва хотод, БНСУ-ын ДНБ-ний 27.5 хувь Сөүл хотод тус тус ногдож байгаа юм. Энэ бол манай улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой томоохон асуудал мөн.

Нийслэлийн нэг хүнд ноогдох нэмүү өртөг 2010 онд 4,6 сая төгрөг болж өмнөх оныхоос нэг сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын дунджаас 1,5 сая төгрөгөөр илүү байна. Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ 2010 онд 3,1 сая төгрөг болж, 2009 оноос 700 гаруй мянган төгрөгөөр нэмэгджээ. Нийслэл Улаанбаатар хотын ДНБ-ний салбарын бүтцийг дэлхийн жишгийн дагуу ерөнхий гурван салбараар авч үзвэл 2010 оны байдлаар 0.5 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 34,6 хувь нь аж үйлдвэр, барилгын салбарт, 64,9 хувь нь үйлчилгээний салбарт тус тус ноогдож байна. Нийслэл Улаанбаатарын эдийн засгийн салбарын бүтэц манай улсын бусад бүс нутгуудтай харьцуулбал боловсронгуй байна гэж хэлж болно. Гэвч аж үйлдвэрт орчин үеийн өндөр технологитой боловсруулах үйлдвэрлэлийн хувийн жин бага, байгальд халтай үйлдвэрлэл зонхилсон, үйлчилгээний салбарын технологийн түвшин хэт доогуур, ХАА-д фермерийн аж ахуй сул хөгжсөн, үүнтэй холбоотойгоор зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүн, тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны хангамж импортоос хараат байдалтай байна. Иймд эдийн засгийн хүрээний эдгээр болон бусад асуудлууд нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусган шийдвэрлэх шаардлагатай, тулгамдсан томоохон чухал асуудлын нэг юм.

4.2. Төсөв, санхүүгийн байдал

Монгол улсад татварын орлого бүрдүүлэх төвлөрсөн тогтолцоо үйлчилж байна. Хэдийгээр Улаанбаатар хотод Монгол улсын эдийн засгийн үйл ажиллагааны талаас илүү хувь нь явагддаг ч энэхүү татварын орлогын тогтолцоо нь хот төвлөрүүлж болох татварын орлогодоо

түшиглэн төрийн үйлчилгээний хангамжийг бие даан санхүүжүүлэх бололцоог хязгаарлаж байна.

Улаанбаатар хотод Монгол улсын эдийн засгийн үйл ажиллагааны талаас илүү хувь нь явагддаг ч Монгол улсын татварын орлого бүрдүүлэх төвлөрсөн тогтолцоо нь Улаанбаатар хот, төвлөрүүлж болох татварын орлогодоо түшиглэн төрийн үйлчилгээний хангамжийг бие даан санхүүжүүлэх бололцоог хязгаарлаж байна. 2010 оны эцсийн байдлаар нийслэлийн төсвийн нийт орлого 164.2 тэрбум төгрөг, зарлага 103.5 тэрбум төгрөг байсан нь улсын нийт орлогын 45,9 хувь болсон байна. Мөн онд улсын нэгдсэн төсөвт 56.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь 2003-2008 онд төсөвт төвлөрүүлсэн **нийт** 123,9 тэрбум төгрөгийн 45 хувьтай тэнцэж байна. Нэг хүнд ногдох төсвийн орлогын хэмжээ 2010 онд 144.8 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 18.0 хувиар, төсвийн зарлага 91.3 мянган төгрөгт хүрч 61.9 хувиар өссөн байна. **Нийслэлийн (Улаанбаатарын бүс)** төсвийн орлого Монгол улсын нийт төсвийн орлогын 45.3 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд орон нутгийн төсвийн зарлагын 34.7 хувийг эзэлж байна.

Хотын эдийн засагт 2010 онд 1779.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2009 оныхоос 2.2 дахин 984.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 72.4 хувийг гадаад, 27.6 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байна. 2010 онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос 3.6 дахин, дотоодын хөрөнгө оруулалт 12.7 хувиар өсчээ. Хотын дүүргүүдийн төсөвт 1.4 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос гадна дүүргүүдээс хотын төсөвт орлого төвлөрүүлсэн байна. Хотын хөгжлийн төлөвлөлт, удирдлагад эдийн засгийн засаглал хөгжиж, бэхжээгүй байгаагаас санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зохистой, тогтвортой түвшинд барихад хүндрэл учирч болзошгүй.

Мөн нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар “Хот татвартай байхыг хуульчилсан боловч улсын “нийслэл”-ийн онцгой чиг үүргийн асуудал бүрхэг байсаар байна.

4.3. Хотын хүн ам, нийгмийн дэд бүтцийн хангамж

4.3.1. Хүн амын тоо, нас, хүйсний бүтэц, байршил, шилжих хөдөлгөөн

Улаанбаатар хотод 2011 оны 1-р сарын 1-ний байдлаар 294.4 мянган өрхийн 1161785 хүн буюу Монгол Улсын нийт хүн амын 41.7 хувь, 5 хүн тутмын 2 нь оршин сууж байна. Манай улсын хүн ам нийслэл хотдоо буюу зөвхөн 1 хотод хэт бөөгнөрсөн байна. Гэтэл дэлхийн олон оронд өнөөдөр үндэсний аюулгүй байдлын хүрээнд хүн амаа нэг болон цөөн тооны хотод хэт бөөгнөрүүлэхээс зайлсхийх бодлогыг хэрэгжүүлж байгаа юм. Жишээлбэл, БНХАУ-ын нийслэл Бээжин хотод нийт хүн амынх нь зөвхөн 1.0 хувь, Япон улсын нийслэл Токио хотод нийт хүн амынх нь зөвхөн 6.4 хувь, ОХУ-ын нийслэл Москва хотод нийт хүн амынх нь зөвхөн 6.0 хувь тус тус оршин сууж байна. Хүн ам нь нийслэл хотдоо харьцангуй бөөгнөрсөнд тооцогддог БНСУ-ын нийслэл Сөул хотод нийт хүн амынх нь 21.3 хувь нь оршин суудаг байна. Улаанбаатар хотод манай улсын хүн амын 41.7 хувь оршин сууж байгаа нь улс орны бүсчилсэн хөгжлийн алсын хараатай оновчтой бодлогын хүрээнд засаж залруулах шаардлагатай байна. Энэ бол нийслэл Улаанбаатар хотын хүн ам зүйн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон тулгамдсан асуудлын нэг мөн.

Нийслэл Улаанбаатар хотын нийт хүн амын 64.9 хувь нь 34 хүртэл насны залуучууд, нийт хүн амын 47,3 хувь буюу 549642 нь эрэгтэй, 52,7 хувь буюу 612143 нь эмэгтэйчүүд байна. Хүн амын дундаж наслалт 68,2 байгаа нь улсын дунджаас бага зэрэг дээгүүр байна. 2010 оны байдлаар манай улсын хөдөлмөрийн насны хүн амын 39.6 хувь, эдийн засгийн идэвхтэй хүн амын 34.4 хувь, ажиллагсдын 32.0 хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна.

Нийслэл Улаанбаатар хотын нийт хүн амын 94.7 хувь төвийн 6 дүүрэгт, 5.3 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус оршин сууж байна. Төвийн зургаан дүүрэгт хүн ам хэт төвлөрсөн байдал ажиглагдаж байна. Энэ нь алслагдсан дүүргүүдийн хөгжлийн түвшин доогуур байгаатай холбоотой юм. Энэ ч бас нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн тулгамдсан асуудлуудын нэг мөн. Нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо сүүлийн 11 жилийн хугацаанд

ердийн өсөлтөөр 124197 хүнээр, механик өсөлтөөр 288140 хүнээр тус тус нэмэгдсэн байна. Хүн амын тооны нийт өсөлтийн гуравны хоёроос илүү хувийг механик өсөлт эзэлж байгаа нь манай улсын бусад бүс нутаг, аймгуудаас нийслэл хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй шууд холбоотой юм. Энэ бол нийслэл Улаанбаатар хотын хөгжилтэй шууд холбоотой бөгөөд улсын хэмжээнд авч үзэж шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлын нэг мөн.

4.3.2. Хүн амын орлого, ажилгүйдэл, ядуурал

Нийслэл Улаанбаатар хотод 2010 оны байдлаар нэг өрхийн сарын дундаж орлого 2009 онтой харьцуулахад оны үнээр 8,6 хувь өссөн байна. Үүнээс цалин хөлсний орлого 10,4 хувиар нэмэгдэж, тэтгэвэр, тэтгэмжийн орлого дунджаар 2,3 хувиар буурсан байна. Өрхийн мөнгөн зарлагыг харахад хүнсний зүйлийн зарлага хотын дунджаар 2010 онд 2009 оныхоос 5,3 хувь, хүнсний бус бараа үйлчилгээний зарлага 4,9 хувь тус тус өсчээ.

Нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийн тоо 2010 оны байдлаар 114355 хүн байгаа нь 2007 онтой харьцуулахад 11,5 хувиар, 2008 онтой харьцуулахад 7,2 хувиар буурч, 2009 онтой харьцуулахад 12,4 хувиар өссөн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2010 оны байдлаар 9100 хүн байгаа нь 2008 онтой харьцуулахад 30,7 хувиар, 2009 онтой харьцуулахад 18,1 хувиар тус тус нэмэгдсэн байна. Ажилгүйдэл их байгаа нь ядуурал тууштай буурахгүй байхын үндсэн шалтгаан юм. Мөн Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд шинээр бий болж байгаа ажлын байрны тоо тогтмол өсч байгаа ч ажилгүй иргэдийн тоо төдийлэн буурахгүй байна. Үүний гол шалтгаан нь тухайн жилд шинээр бий болж буй ажлын байртай тэнцэхүйц хэмжээний хүн нийслэлд шилжин ирж байгаатай холбоотой. Нийслэлд ажил эрхлэх боломж байгаа ч шилжин ирэгсэд нь мэргэжил, ур чадварын хувьд гологдож байна. Үндэсний статистикийн хорооны мэдээнээс үзэхэд Нийслэл Улаанбаатар хотод 2007-2008 онд хийгдсэн өрхийн орлого, зарлагын судалгаагаар ядуурлын хамралтын хүрээ 21,9 байсан бол, 2009 онд хийгдсэн өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар ядуурлын хамралтын хүрээ 26,7 болж нэмэгдсэн байна. Харин 2010 онд хийгдсэн өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар ядуурлын хамралтын хүрээ 29,7 болж өмнөх оноос эрс нэмэгджээ. Ядуурлын гүнзгийрэлт 2007-2008 онд 6,3 байсан бол 2009 онд 6,4, 2010 онд 7,7 болж мөн нэмэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор дэлхийн өндөр хөгжилтэй болон дундаж хөгжилтэй орнуудын нийслэл хотуудтай харьцуулбал ядуурал олон дахин өндөр байна. Энэ бол шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлын нэг мөн.

4.3.3. Боловсрол, соёлын үйлчилгээний хүртээмж

Нийслэл Улаанбаатар хотод сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар ихээхэн доогуур түвшинд байна. Боловсролын үйлчилгээний өсөлт хүн амыг өсөлтийг гүйцэхгүй байгаатай холбоотойгоор сургууль, цэцэрлэг дутагдаж нэг ангид хичээллэх хүүхдийн тоо олон байна. Улаанбаатар хотод манай улсын ЕБС-ийн суралцагчдын 35,3 хувь нь суралцаж байгаа боловч нийт сургуулийн 27,7 хувь ногдож байна. Анги танхим дутагдалтай байгаагаас зарим сургууль өдөрт 3 ээлжээр хичээллэж байна. ЕБС-д суралцаж байгаа хүүхдийн тоонд харгалзах сургуулийн тоог тооцож үзвэл дахиад 100 орчим сургууль шинээр барих шаардлагатай байна. Түүнчлэн манай улсын сургуулийн өмнөх насны боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн 40,9 хувь нь нийслэл Улаанбаатар хотод байгаа боловч нийт цэцэрлэгийн 31,4 хувь ногдож байна. Нийслэлийн хэмжээгээр 2-5 насны цэцэрлэгт хамрагдвал зохих нийт хүүхдийн 69,8 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Хувийн өмчийн цэцэрлэгүүдэд нийт 7794 хүүхэд сурч хүмүүжиж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 1214 хүүхдээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй үндсэн багшийн тоо 1.8 мянгад хүрч, цэцэрлэгийн нэг багшид дунджаар 30.6 хүүхэд ногдож байна. Улсын дундажтай харьцуулахад нийслэлийн цэцэрлэгийн нэг багшид ноогдох хүүхдийн тоо дунджаар 4 хүүхдээр олон байна.

Сургууль, цэцэрлэг дутагдалтай байгаатай холбоотой хамран сургалтын хувь Улаанбаатар хотод багасч байгаа нь томоохон тулгамдсан асуудал юм. 2009-2010 оны хичээлийн жилд Нийслэлд ерөнхий боловсролын 206 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрийн бус өмчийн сургуулийн тоо 96 буюу нийт сургуулийн 46.6 хувийг эзэлж байна. Нийт ЕБС-иудын 66.0 хувь нь нийслэлийн Сүхбаатар, Баянгол, Баянзүрх дүүргүүдэд төвлөрч байна.

Төрийн бус өмчийн сургуулийн тоогоор Сүхбаатар, Баянгол дүүргүүд бусад дүүргүүдээс олон байгаа ба хувийн сургуулиудын 58.3 хувь нь тус 2 дүүргийн нутаг дэвсгэрт байршин сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жин улсын дунджаар 94.8 хувь байхад Улаанбаатар хотод 92.8 хувь болж 2 пунктээр багассан байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жин багасах нь бичиг үсэг тайлагдалтын түвшинг бууруулах сөрөг үр дагавартай байдаг.

Мөн дунд боловсролын хамран сургалтын бохир жин улсын дунджаар 94.7 хувь байхад Улаанбаатар хотод 93.8 хувь болж мөн 0,9 пунктээр багассан байна.

Улсын дундажтай харьцуулахад анхан шатны боловсролын хүртээмж Улаанбаатар хотод өндөр байна. Манай улсын ихэнх их дээд сургуулиуд Улаанбаатар хотод төвлөрчээ. 2010 оны байдлаар улсын нийт оюутны 95,3 хувь, их, дээд сургуулиудын 88,5 хувь нийслэл Улаанбаатар хотод байршиж байна. Гэвч сургалтын чанар зарим улс орны нийслэл хотын их, дээд сургуулиудын сургалтын чанартай харьцуулбал ихээхэн доогуур түвшинд байна.

Нийслэл Улаанбаатар хотод 3.2 сая ширхэг номын фондтой, нийт 1672 суудал бүхий уншлагын танхимтай 28 нийтийн номын сан ажиллаж байна. Музейн үзэгчдийн 57.1 мянга нь хүүхдүүд байгаагаас 49.1 хувь нь буюу 28.0 мянга гаруй хүүхэд Байгалийн болон Үндэсний түүхийн музейг үзсэн байна. Мөн 2010 онд манай оронд зочилсон гадаадын 75.1 мянган жуулчид дээрх музейнүүдийг үзэж сонирхсон нь нийт үзэгчдийн 35.9 хувийг эзэлж, өмнөх оныхоос музей үзсэн гадаад зочдын тоо 20.5 мянгаар нэмэгджээ.

Нийслэл Улаанбаатар хотод 2010 онд 2284 суудал бүхий 3 кино театр үйл ажиллагаа явуулж, нийт 12515 удаагийн кино гаргалтаар 984.6 мянган үзэгчдэд үйлчилж, 4.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

4.3.4. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Мэргэжлээрээ ажиллаж байгаа их эмч нарын 60,8 хувь нь нийслэлд ажиллаж, нэг их эмчид ойролцоогоор 248 хүн ноогдож байгаа нь манай орны хувьд хамгийн өндөр үзүүлэлт байх боловч эрүүл мэндийн бусад үзүүлэлтийн хувьд тэр хэмжээгээрээ илүү байж чадахгүй байна. Жишээлбэл, 2010 оны байдлаар нийт төрөлтийн 42,4 хувь нь Улаанбаатар хотод ноогдож байгаа бөгөөд 1000 амьд төрөлт бүрт нялхсын эндэгдэл 18,2 байгаа нь улсын дундаж буюу 20-иос ялимгүй дээгүүр, төрөхийн улмаас эндсэн эхийн 46 хувь нь Улаанбаатар хотод ноогдож байна. 10000 хүн амд ноогдох халдварт өвчнөөр өвчлөгсөд, нас баралтын хувьд улсын дунджаас 0,2 ба 0,9 пунктээр доогуур байна.

Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын 49.0 хувь буюу 18.9 мянган хүн Улаанбаатар хотод ажиллаж байна. Мөн их эмч нарын 60,8 хувь, эм зүйч нарын 78,5 хувь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны 43.1 хувь нь тус тус нийслэл хотод ажиллаж байна. Гэвч эрүүл мэндийн үйлчилгээний чанар бусад улс орны нийслэл хотуудын эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээний чанартай харьцуулбал ихээхэн доогуур түвшинд байна. Нарийн мэргэшлийн оношилгоо, эмчилгээг өндөр болон дундаж хөгжилтэй орнуудын түвшинд хийж чадахгүй байгаагаас үүдэн олон өвчтөн гадаад орнуудад оношилгоо, эмчилгээ хийлгэж их хэмжээний валют гадагш урссаар байна.

Эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагын эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хотод I шатлалын өрхийн эмнэлэг 110, II шатлалын эмнэлэг 9 дүүрэгт, тусгай мэргэжлийн

III шатлалын 10 эмнэлэг тус тус ажиллаж байна. Эдгээр эмнэлгүүдээс сэтгэцийн эмгэг судлалын төвийн архаг болон асрамжийн үйлчилгээнд хамаарах үйлчилгээний тасаг, хавдар судлалын эмнэлгийн туяа эмчилгээний тасаг, мөн халдвартын эмнэлгийн зарим тасгуудыг хот орчмын бүсэд шилжүүлэх шаардлагатай болсон байна.

V БҮЛЭГ. ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

5.1. Монгол улсын тээврийн хөгжлийн тойм

Монгол улсын нийгэм, эдийн засгийн амьдралд тээврийн салбар онцгой чухал үүрэг гүйцэтгэж байна. Тус улсын тээврийн салбар нь төмөр зам, авто замын тээвэр, иргэний нисэх, усан замын тээврийн төрлүүдийг багтаадаг.

Манай улсын зам харилцааны нийт сүлжээнд авто замын сүлжээний урт зонхилох хувийг эзэлдэг. Үүнд:

- Авто замын нийт урт 2010 оны байдлаар 49.3 мян.км.
- Төмөр замын нийт урт 1815 км байна.
- Агаарын замын нийт урт 46,5 мян.км.
- Усан замын сүлжээ 0,5 мян.км орчим юм.

Хүснэгт 5.1.1. Бүх төрлийн тээврийн замын сүлжээ

Тээврийн төрлүүд	Замын сүлжээний нийт урт /мян.км/	Хувийн жин, %
Авто замын тээвэр	49,308	50,25
Төмөр замын тээвэр	1,815	1,85
Иргэний агаарын тээвэр	46,5	47,39
Усан замын тээвэр	0,5	0,51
Дүн	98,123	100,00

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл, 2009

Сүүлийн жилүүдэд авто замын тээврийн хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэн статистик харагдаж байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүн ялангуяа нүүрсийг шууд авто тээврээр урд хөрш рүү тээвэрлэж байгаатай холбоотой юм.

Усан замын тээврийн гол сүлжээ Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрнөөр өнгөрөх бөгөөд нийт ачаа тээвэрлэлтэд өчүүхэн хувийн жин эзэлдэг.

1990 оноос хойших зах зээлийн шилжилтийн эхний он жилүүдэд манай улсын эдийн засаг зөвхөн өөрийн орны бодит боломжийн хэрээр ажиллах болсноор экспортын үйлдвэрлэл, техникийн зориулалттай ачааны хэмжээ багасч, эх орны үйлдвэр болон хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний хэмжээ, түүхий эдийн үйлдвэрлэл, нийлүүлэлт буурч тээврийн салбарын ажил, үйлчилгээний хэмжээ, ялангуяа төмөр зам болон авто замын тээврийн ачаа тээвэрлэлт 1995 он гэхэд 1990 оныхоос 2.0 дахин, зорчигч тээвэрлэлт 1.2 дахин багассан юм. Харин 1998 оноос эхлэн өсөх хандлага гарч цаашид эдийн засгийн үзүүлэлт өсөхийн хэрээр улам нэмэгдэх төлөвтэй байна.

Тээврийн төрлүүдийн ачаа тээвэрлэлтийг 5 жилийн мөчлөгөөр харуулбал:

Хүснэгт 5.1.2. Ачаа тээвэрлэлт

№	Тээврийн төрлүүд	1990	1995	2000	2005	2010
Ачаа эргэлт, сая.т.км						
1	Төмөр замын тээвэр	5085,9	2279,5	4282,4	9947,7	10286,7
2	Авто замын тээвэр	1745,2	152,9	126,1	311,0	1834,0
3	Иргэний агаарын тээвэр	7,8	4,5	9,4	8,3	4,2
4	Усан замын тээвэр	-	0,2	-	0,1	-
	Дүн	6838,9	2437,1	4417,9	10267,1	12124,8

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл, 2010

5.1.1. Авто замын тээвэр

❖ Улаанбаатар хотын тээврийн хэрэгсэл


2008 онд автомашины жилийн дундаж өсөлт 15.3 хувьтай байсан бол 2009 онд 23.0 хувь болж нэмэгдсэн. Улаанбаатар хотод 2009 оны тээврийн хэрэгслийн тооллогоор 131 мянган тээврийн

хэрэгсэл, үүний 100 мянга нь суудлын автомашин 2010 онд 162710 тээврийн хэрэгсэл тоологдсоны 118573 нь суудлын автомашин байна.

2011 онд Нийслэлийн хэмжээнд 209791 тээврийн хэрэгсэл тоологдсоны 166497 нь хувийн тээврийн хэрэгсэл байна.

2009 онд бүртгэгдсэн нийт 131447 тээврийн хэрэгслийн 61599 нь баруун гар талдаа жолооны хүрдтэй буюу Япон, Гонконг болон Англи улсаас импортоор оруулж ирсэн автомашин байна. Харин 2011 онд 209791 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 111229 нь баруун талдаа жолооны хүрдтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 53 хувийг эзэлж байна. 2011 онд 45401 суудлын автомашин зөв буюу зүүн талдаа жолооны хүрдтэй байхад 102589 автомашин баруун талдаа жолооны хүрдтэй байна.

Дүрслэл 5.1.1.1. Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн өсөлт /2000-2011/



❖ Авто парк, авто тээвэр

Улаанбаатарын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 206 км хатуу хучилттай, 180 км сайжруулсан хот хоорондын болон орон нутгийн авто зам байдаг. Баруун аймгууд болон Багануур, Багахангай, Гачуурт, Тэрэлж, Налайх, Хонхор, Шувуун фабрик, Био-Сонгино хаяа хот, тосгод хатуу хучилттай замаар холбогдсон. Авто тээврээр улсын хэмжээнд 2009 онд тээвэрлэсэн нийт зорчигчийн 86.9 хувь нь, тээсэн нийт ачааны 31.1 хувь нь нийслэл хотод ногдож байна.

Эдгээр автомашинууд зүүн гарын дүрмээр явахад зориулагдсан бөгөөд гэрлийн тусгал нь зүүн тийш илүү тусгалтайгаар үйлдвэрлэгдсэн байдаг ба ийм жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл нь замын зорчих хэсгийн баруун гарын дүрмээр явах үедээ шөнийн цагт өөдөөс ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн нүдийг гялбуулж зам тээврийн осол гэмтэл гарах үндсэн нөхцөл бүрдүүлж байна.

Хүснэгт 5.1.1.1. Авто тээврийн үндсэн үзүүлэлт

	Тээсэн ачаа /мян.тн/		Улсын дүнд УБ эзлэх хувь	Тээвэрлэсэн зорчигч		Улсын дүнд УБ эзлэх хувь
	Улс	Нийслэл		Улс	Нийслэл	
2009 он	10563.8	3288.5	31.1	229.0	199.0	86.9
2008 он	9255.7	3075.1	33.2	226.9	193.0	85.1
2007 он	9207.1	3460.0	37.6	205.0	156.4	76.3
2004 он	7561.9	760.3	10.1	189.6	152.3	80.3

1990 оноос Ачаа тээврийн удирдах газар хувьчлагдсанаар улсын хэмжээнд авто замын ачаа тээврийн удирдлага зохицуулалт алдагдсан учраас ачаа тээврийн төв, авто парк улс, орон нутагт хаана ч байхгүй болсон бөгөөд "Горьдлого бааз" нэртэй тээврийн хэрэгслийн зогсоол Хот хоорондын зорчигч үйлчилгээний төв буюу авто вокзалын орчимд байрлаж хотын авто замын хөдөлгөөн болон замын чанарт ихээхэн хохирол, хүндрэл учруулж байдаг.

Ерөнхийдөө хотын баруун чиглэлд Гурвалжингийн гүүр орчимд, хотын чиглэлд Баянзүрхийн авто вокзалын дэргэд төвлөрч байна.

Цаашид удирдлага, зохицуулалтын хувьд ч тээвэр зохицуулалтын хувьд ч төлөвлөлтөнд тусгаж шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудал юм.

Хүснэгт 5.1.1.2. Ачаа тээвэрлэлт /ткм /

№	Тээврийн төрлүүд	1990	1995	2000	2005	2010
Ачаа тээвэрлэлт, мян.тн						
1	Төмөр замын тээвэр	14523,6	7298,0	9158,5	15586,3	16804,0
2	Авто замын тээвэр	35651,1	1648,5	1480,4	9617,4	12610,2
3	Иргэний агаарын тээвэр	10,8	2,7	2,9	2,0	1,6
4	Усан замын тээвэр	-	1,6	-	0,5	-
	Дүн	50185,1	8950,8	10643,4	25206,2	29415,9

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл, 2010

Авто замын тээврийн ачаа тээвэрлэлт багасч 1995 он гэхэд 1990 оныхоос 2.0 дахин, зорчигч тээвэрлэлт 1.2 дахин багассан. Харин 1998 оноос эхлэн өсөх хандлага гарч цаашид эдийн засгийн үзүүлэлт өсөхийн хэрээр улам нэмэгдэх статистик харагдаж байна.

❖ Зорчигч тээвэр

Улаанбаатар хот нь хот хоорондын болон хот орчмын зорчигч тээврийн үйлчилгээтэй. Хот хоорондын зорчигч тээврийн үндсэн 2 авто вокзалтай. Хот хоорондын 50 гаруй чиглэлд 1300 гаруй автобус үйлчилдэг байна.

- Баянзүрх дүүргийн Авто вокзал, тээвэр оношлогооны төв,
- Сонгинохайрхан дүүргийн Драгон ХХК-ийн байрны 1-р давхарт, тэдний эзэмшлийн газар дээрх “Драгон” төв

Хот орчмын зорчигч тээврийн 13 чиглэлд төрийн болон хувийн хэвшлийн 10 гаруй аж ахуйн нэгж байгууллагын том оврын 63 автобус, 6 чиглэлд 23 микро автобус үйлчилдэг. Зорчигч тээврийн үйлчилгээний чиглэл, эцсийн буудлын судалгаанаас, зорчигч үйлчилгээний орчин, эцсийн буудлын байршил, техник, үйлчилгээ оношлогооны асуудлыг цогцоор нь авч үзэж шийдвэрлэх шаардлагатай байдал харагдаж байна.

Хүснэгт 5.1.1.3. Хот орчмын зорчигч тээврийн үйлчилгээ

Д/Д	Зорчигч үйлчилгээний чиглэл	Байгууллага, аж ахуйн нэгж	Эцсийн буудал
❖ Том оврын автобус үйлчилгээ			
1	Өлзийт-Төв номын сан	“Автобус-1” НӨҮҮГ	Төв номын сан
2	Хужирбулан-Сүхбаатарын талбай-Санктпетрбург	“Автобус-3” НӨҮҮГ	Санктпетрбург
3	Найрамдал зуслан –Цамбагарав -Саппоро	“Сутайн Буянт” ХХК	Саппоро
4	ГАЧУУРТ ТОСГОН-ХӨСҮТ		ХӨСҮТ
5	Шаргаморьтын зуслан - МУБИС-ХӨСҮТ	“Эрдэм Трасс” ХХК	ХӨСҮТ
6	Туул- Шувуу- Вокзал		Вокзал
7	Биокомбинат - Морингийн даваа -МУБИС		МУБИС
8	Санзай -“Бөмбөгөр” худалдааны төв		“Бөмбөгөр” худалдааны төв
9	Городок-УБИС	“Морьбарьдаг” ХХК	МУБИС
10	Налайх-Вокзал		Вокзал
11	“Ургах наран” хороолол -Вокзал		Вокзал
12	Тэрэлж - Вокзал	“Ирээдүйн аяны зам” ХХК	Вокзал
13	Хонхор -Вокзал		Вокзал
❖ Микро автобус үйлчилгээ			
14	Эмээлт - Саппоро		Саппоро
15	Тахилт - Саппоро		
16	Мал бордох - Саппоро		
17	Баруун туруун - Саппоро		
18	Жаргалант - 361 гарам - Хархорин		Хархорин
19	Хилийн цэргийн 326-р анги - Биокомбинат		Нисэхийн эцэс

Зорчигч тээврийн үйлчилгээ нь удирдлага, зохицуулалтын хувьд хот хоорондын зорчигч тээвэр нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автозамын алба, Улаанбаатар хот орчмын зорчигч тээвэр нь Нийслэлийн Нийтийн тээврийн газарт харьяалагддаг.

Авто замын ачаа тээвэр болон зорчигч тээврийн хяналтын үүрэг бүхий Шалган бүртгэх товчоод Нийслэлийн Автозамын газар, улсын чанартай ШБТовчоод нь ЗТБХБЯамны харьяа Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын албанд харьяалагддаг байна.

5.1.2. Агаарын тээвэр

Буянт-Ухаад байрлах нийслэлийн агаарын тээврийн нисэх буудал олон улсын болон орон нутгийн иргэний агаарын тээвэр, ачаа тээвэр, шуудангийн тээврийн үйлчилгээ явуулдаг. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа төв, орон нутгийн 18 нисэх буудал, хувийн хэвшлийн 2 нисэх буудалтай.

Баруун Европыг зүүн өмнөд Азитай холбосон олон улсын 9, орон нутгийн 27 чиглэлд нислэг хийдэг.

2010 оны статистикийн үзүүлэлтээр олон улсын 4930, орон нутгийн 5748, нийт 11758 нислэг, ачаа тээврийн 3933, шуудангийн 559 үйлчилгээ үзүүлсэн.

Олон улсын нислэгийн дамжин өнгөрөлт 2000 онд 27711 байсан бол 2010 онд 72985 болж бараг 3 дахин нэмэгдсэн. Нисэх буудлын хөөрч, буух чиглэл нь ганц чиглэлтэй байгаа нь олон улсын буудлын ангилалд тохиромжгүй учир Монгол улсын Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 140-р тогтоолоор Хөшигийн хөндийд “Олон улсын нисэх онгоцны буудал”-ын зориулалтаар 12084.9 га газрыг тусгай хэрэгцээнд авч нисэх буудлыг даган бий болох 100 мянга орчим хүн амтай хотын ерөнхий төлөвлөгөөг 1224.8 га талбайд хийсэн. Энэхүү буудал нь Дэлхийн нисэх буудлыг дагасан хотуудын Монгол дахь **hub** буюу зангилаа байж, олон улсын бизнес, эдийн засаг, нийгэм, улс төрийн хамтын ажиллагааны төв буюу дээд хэмжээний уулзалт, арга хэмжээ зохион байгуулдаг олон улсын төв хот болох үзэл баримтлалтай.

5.1.3. Монгол улсын төмөр замын сүлжээ

Монгол улс нийт 1815 км шугамтай. Үүнээс Улаанбаатар төмөр зам нь 1110 км, түүнээс салбарласан Салхит-Эрдэнэт 164 км, Дархан-Шарын гол 63 км, Багахангай-Багануур 96 км, Толгойт-Сонгино 21 км, Хонхор-Налайх 13км, Айраг-Бор-Өндөр 60 км, Сайншанд-Зүүн баян 50 км замтай, Эрээнцав-Баянтүмэний 238 км зам, гол шугамын дагуу 69 өртөө зөрлөг, салбар шугамуудыг оролцуулбал 83, Баянтүмэн тасгийг оролцуулан тооцоход 88 өртөө зөрлөгтэй байна. Зүтгүүрийн үндсэн 3 депо Улаанбаатар, Сайншанд, Дархан өртөөнд, эргэлтийн 5 депо Сүхбаатар, Замын-Үүд, Айраг, Эрдэнэт, Баянтүмэн өртөөнд, зам засварын 5 анги Дархан, Улаанбаатар, Чойр, Сайншанд, Салхит өртөөнүүдэд, зам засварын машинт станц Улаанбаатарт түүний харьяа угсрах бааз Салхитад тус тус байрлана. Бетон дэрний үйлдвэр Хөтөлд, модон дэрний үйлдвэр Зүүнхараад, ул шорооны буталсан чулуу бэлтгэх үйлдвэр Олон овоот зөрлөгт, дохиолол холбооны 3 анги Дархан, Улаанбаатар, Сайншанд өртөөнд, эрчим хүчний 2 анги Улаанбаатар, Сайншанд өртөөнд байрлаж байна.

5.1.4. Улаанбаатарын бүсийн төмөр замын сүлжээ.

Улаанбаатар хотоор дайрч өнгөрөх Монголын төмөр замын гол шугам олон улс, зах зээлийн төвүүдтэй төмөр замын тээврийг хүргэдэг дамжин өнгөрөх шугамын үүрэг гүйцэтгэдэг улс, орны эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Нийслэл Улаанбаатар хотод төмөр замын үйл ажиллагааны амин сүнс болсон тулгуур өртөөд, хөдлөх бүрэлдэхүүн, зам, дохиолол холбооны засвар, ашиглалтын төвүүд бөөгнөрсөн байдаг. Улаанбаатар төмөр замын гол шугамын Эмээлт өртөөнөөс /378 дугаар км/ Багахангай /509 дүгээр км/ хүртэлх нийт 121 км зам Улаанбаатар бүсэд

хамаарах бөгөөд Улаанбаатар хотод орж, гарч, дамжин өнгөрч байгаа олон улс, орон нутгийн бүх ачаа, зорчигч тээврийн ажлын 98-99 хувийг гүйцэтгэж байна

Дүрслэл 5.1.4.1.

Улаанбаатар бүсийн төмөр замын сүлжээ, өртөө, зөрлөгийн байршил



Төмөр замын гол замын дагуу Улаанбаатар зангилааны үндсэн өртөө болох Улаанбаатар 1,2, Толгойт, Амгалан өртөөнүүдээс гадна Эмээлт, Туул, Хонхор, Бумбат, Баян, Хайрхан, Хоолт, Цагаан хяр, Чулуут, Хангай, Багахангай зэрэг завсрын 11 өртөө, зөрлөг байрладаг.

Хүснэгт 5.1.4.1. Улаанбаатар бүсэд хамаарах өртөөнүүдийн техникийн үзүүлэлт

	Өртөө, зөрлөг	км	Зай *	Зэрэг	Замын тоо	Замын хязг. урт	Нэвтрүүлэх чадвар, хос г/т*	Ачилт/буулгалт 2010. мянг.т.
1	1. Эмээлт	378	9	5	3	862	12	0/0
2	2. ТОЛГОЙТ	395	17	1	7	825	12	29.3/1071.4
3	3. УБ-2	399	4	Анги- гүй	4	1109	32	173.0/5828,6
4	4. УЛААНБААТАР	402	3		18	728	50	
5	5. АМГАЛАН	412	10	3	5	767	22	143.8/28.1
6	6. Туул	419	7	5	3	1352	26	0/0
7	7. Хонхор	430	11	4	5	792	18	4.7/48.7
8	8. Бумбат	439	9	5	2	1050	18	0/0
9	9. Баян	450	11	5	3	873	18	0.12/6.6
10	10. Хайрхан	459	9	5	2	996	18	0/0
11	11. Хоолт	468	9	5	3	1210	18	0/0
12	12. Цагаан хяр	477	9	4	3	1240	18	0/0.16
13	13. Чулуут	487	10	5	2	1054	18	0/0
14	14. Хангай	497	10	5	2	1017	18	0/0
15	15. Багахангай	509	12	2	6	1270	18	0.6/15.2

* Өмнөх өртөөнөөс тухайн өртөө хүртэл

** Галт тэрэгний жинг 2М62 зүтгүүрийн хүчин чадлаар тооцоолжээ.

Дээрх үзүүлэлтээс харахад ачих, буулгах, галт тэрэг найруулах, задлах, ялгах ажлын ихэнх нь УБ, Толгойт өртөөнд багахан хэсэг нь Амгалан өртөөнд хийгдэж бусад өртөөнүүд галт тэрэг дамжуулах, зөрүүлэх үүрэгтэй нь харагдаж байна. Баян

зөрлөгийн орчимд Туушин компанийн байгуулж буй Ложистикийн терминал байгуулагдсанаар Улаанбаатар зангилааны ачаалал эрс өөрчлөгдөнө.


- Багануур-Багахангайн 96 км төмөр зам 1978 онд ашиглалтанд орсон, Булагтай, Гүнгалуутын завсрын 2 зөрлөгтэй. Багануурын уурхайн нүүрсийг тээвэрлэж Улаанбаатар болон бусад хотуудын дулааны цахилгаан станцуудын түлшний хэрэгцээг хангах гол үүрэгтэй бөгөөд сүүлийн жилүүдийн ачаа урсгалын байдалд дүн шинжилгээ хийхэд нүүрснээс бусад ачаа 10 орчим хувь болж байна. Өнгөрсөн хугацаанд 7 хоногт 2 удаа суудлын галт тэрэг явж байсан боловч зорчигчийн тоо Улаанбаатар чиглэлд 30 хувь, эсрэг чиглэлд 3-5 хувиас хэтрэхгүй байсан тул 2008 оноос зогсоосон байна.
- 1938 онд ашиглалтанд орсон Улаанбаатар-Налайхын нарийн төмөр замыг 1956 онд буулгаж Налайх-Хонхорын 14 км замыг гол шугамтай холбосон байдаг. Нүүрс тээвэрлэх зориулалттай боловч сүүлийн 4 жил огт тээвэр хийгдээгүй байгаа учир цаашид хэрхэн ашиглах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.
- Сонгино-Толгойтын 21 км төмөр замыг Улаанбаатар хотын хэрэгцээнд зам, барилгын хайрга тээвэрлэх зориулалтаар 1980 онд ашиглалтанд оруулжээ. Энэ зам захын 2 өртөө нь дундаа Сонсголон хэмээх зөрлөгтэй байна. Улаанбаатар төмөр замын тайлангаас үзэхэд түүгээр жилд 200-300 мянган тн ачаа тээвэрлэж байгаа хэдий ч улирлын байдлаас шалтгаалж үлэмж хэлбэлзэлтэй байсан бол 2007 оноос эхлэн эрс буурч бараг тасалдах хандлагатай болсон байна. Нийслэл хотод их бүтээн байгуулалтын ажил авто зам, барилгын ажил жилээс жилд нэмэгдэж, материалын хэрэгцээ асар ихээр нэмэгдэж байхад зориулалтын замын ашиглалт буурч байгаа нь анхаарал татах зүй ёсны асуудал. Цаашид төмөр замын трассын өөрчлөлттэй холбогдон энэхүү зам нь хоёр замыг холбосон дамжлага болох юм. Ийм учраас мөн цаашид хэрхэн зохистой ашиглах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

5.1.4.1. Улаанбаатар зангилаа төмөр замын сүлжээ

Улаанбаатар зангилааны төмөр замын сүлжээ гэдэгт хот дотор орших Эмээлт, Толгойт, Улаанбаатар-2, Улаанбаатар, Амгалан өртөө, тэдгээрийг холбосон 112 км нь гол зам, 162 км нь салаа болон салбар замууд, туслах байгууламжууд орох бөгөөд нийт 2183.53 га эдэлбэр газрыг хамарч байна.

1947 онд хоёр улсын засгийн газрын хэлэлцээрээр болон 1952 оны нэмэлт газар олголтоор нийслэлд төмөр замын байгууллагуудад зориулж 154.0 га талбай, өртөөдөд 3000Х300 м талбай, гол замын дагуу аюулгүй бүсэд зориулж 120 м өргөнтэй зурвас газар олгосон.

Дүрслэл 5.1.4.1.1. Улаанбаатар өртөөний байршил




Төмөр зам нь хотыг үндсэндээ 2 хувааж байгаа бөгөөд төмөр замын туслах байгууламжууд болох Ялгах өртөө, Вагон засварын газар, Зүтгүүрийн депо, Вагон депо зэрэг үйлчилгээний газрууд нь хотын төвд байрласан нь хот төлөвлөлтийн үндсэн

зарчим, хотын эрүүл ахуйн норм нормативд нийцэхгүй байгааг удаа дараагийн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж зориулалт үйл ажиллагааг өөрчлөх асуудлыг тусгаж байсан.

❖ **Улаанбаатар өртөө, салаа зам тэдгээрийн үүрэг, зориулалт**

Улаанбаатар өртөө 1956 онд ашиглалтанд орсон, төмөр замын ачаа, зорчигч тээврийн ажил төвлөрсөн, ангилалгүй, хамгийн том өртөө бөгөөд тус өртөөний ачааллыг хөнгөвчлөх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2000 онд Улаанбаатар-2 өртөөг шинээр байгуулснаар энэ 2 өртөө бие даасан үйл ажиллагаатай болсон. Улаанбаатар өртөөний нутаг дэвсгэрт дээр дурдсан хоёр өртөөнөөс гадна зүтгүүрийн депо, суудлын вагон депо, Улаанбаатар вокзал, замын II анги, дохиолол холбооны II анги, эрчим хүч, ус хангамжийн I анги, ачих, буулгах, тээвэр-экспедицийн механикжсан анги, төмөр замын нэгдсэн эмнэлэг, төмөр замын дээд сургууль зэрэг томоохон байгууллагууд, үйлдвэрлэл үйлчилгээний жижиг нэгжүүд, төмөр замчдын орон сууцны хороолол байрлана.

Улаанбаатар-1 өртөө нь төмөр зам ашиглалтын үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг хэсгийн ялгах өртөө бөгөөд паркийн урт, өргөн 2000X160м, терминал дээр салбарласан салаа замуудтай, эдгээр нь авто замтай олон дахин огтлолцдог. Тухайлбал ДЦС-3-ын салаа зам авто замтай 15 удаа, Комбинатын салаа зам Чингисийн өргөн чөлөөний авто замтай нэг түвшинд огтлолцдог байна.



Улаанбаатар-2 өртөө нь ачаа тээврийн зориулалттай завсрын өртөө бөгөөд 1990-ээд оны эцсээр Үйлдвэрийн зөрлөг нэртэй байгуулагдаж 2000 оноос Улаанбаатар-2 өртөө гэж нэрлэгдэх болсон. Паркийн урт, өргөн 1800X40м.

- Улаанбаатар зүтгүүрийн депо нь илчит тэрэгний ашиглалт, засварын үйл ажиллагаа эрхлэх төмөр замын хамгийн төв аж ахуйн нэгж, 1956 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Гол замын 39 зүтгүүр, сэлгээний 17 зүтгүүртэй. Зүүн хараа-Чойрын чиглэлийн салбар замуудад тээврийн ажил үйлчилгээ үзүүлэхээс гадна илчит тэрэгний засвар үйлчилгээ эрхэлдэг. Дэвсгэр газрын хэмжээ 1900X100м.
- Суудлын вагон депо зорчигч үйлчилгээ, суудлын вагон ашиглалт, засвар үйлчилгээг бүрэн хариуцдаг. 285 вагонтой, орон нутгийн зорчигч тээврийн зэрэгцээ Москва, Иркутск, Бээжин, Хөх хот хүртэл олон улсын зорчигч үйлчилгээнд оролцдог. 13 ширхэг салаа замтай, дэвсгэр газар нь 1600X70м.
- Ачих буулгах тээвэр-экспедицийн механикжсан анги нь 1950-аад оноос УБ өртөөний харьяалалд байж байгаад 1969 оноос бие даасан аж ахуйн нэгж болсон. Улаанбаатар, Толгойт болон бусад томоохон өртөөнд салбартай, ачаа ачих, буулгах, үйлчлүүлэгч байгууллагуудад хүргэж өгөх, татаж авах үүрэг гүйцэтгэдэг. Улаанбаатарын терминалиар УБТЗ-ын Тээвэр зуучийн төв, Ильинск экспресс зэрэг тээвэр зуучийн

байгууллага үйлчлүүлдэг. Ачих, буулгах зам, өргөх, зөөх төхөөрөмж, терминалийн агуулах нийт 5.0 га талбайтай.

Замын II анги нь гол замын Түнхэл өртөөнөөс Наран-элгэн хүртэлх салбар ба салаа замуудын хэвийн ажиллагаа, арчилгааг хангах мэргэжлийн байгууллага. Гол замын нийт урт 400км, удирдлага, захиргаа нь Улаанбаатарт төвлөрдөг машин механизм нь Улаанбаатар өртөөний баруун жигүүрт 4 богино салаа дээр байрладаг.


Толгойт өртөө нь Улаанбаатар хотод орших хоёр дах томоохон өртөө, 1950 онд ашиглалтанд орсон. 1990 оноос I зэрэглэлийн ялгах өртөө болсон. 1 ба 2 гэсэн хоёр парктай, парк тус бүр 7 замтай. Эдэлбэр газар буюу паркийн хэмжээ 2100X50м. Тус өртөөнөөс Сонгины салбар зам, ТЭЦ-4, мах, гурилын комбинат, үе угсрах бааз зэрэг салаа замуудтай, эдгээр нь авто замтай нэг түвшинд огтлолцдог.

Дүрслэл 5.1.4.1.3. Толгойт өртөөний байршил



Амгалан өртөө нь III зэргийн завсрын өртөө бөгөөд 1956 онд ашиглалтанд орсон. Энд УБТЗ-ын машинт станц, төв засварын газар, материал техникийн төв агуулах зэрэг байгууллагууд тус тусдаа салаа зам эзэмшдэг. Паркийн урт 850X35м.

Дүрслэл 5.1.4.1.4. Амгалан өртөөний байршил




Зам засварын машинт станц нь замын их засварын ажил эрхэлдэг, 1970 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн. Жил бүр 25км-70 км зам засварын ажил үйлчилгээ хийнэ. Төмөр замын Амгалан өртөөний зүүн жигүүрт байрладаг, 3 замтай, машин механизмын засвар, хүчилтөрөгч, металл эдлэл үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг.

1990 оноос өмнө ашиглагдаж байгаад орхигдсон, Улиастайн гол дагасан салаа зам ажиллаж байна

Төмөр замаар үйлчлүүлэгчдийн хэрэгцээ өсөх тусам тээвэр зуучийн байгууллагууд, томоохон компаниудын салаа зам нэмэгдэж, байгууллага бүр салаа бие даасан салаа замтай болох эрмэлзлэл давамгайлах болсноор Улаанбаатар хотын зам, тээврийн сүлжээнд ноцтой хүндрэл учруулж байгаа учир нэгдсэн терминаль байгуулан хотын үйлчилгээ хангамжид зайлшгүй шаардлагатай бус үйлчилгээг шилжүүлж салаа замуудыг цөөрүүлэх шаардлагатай.

Дүрслэл 5.1.4.1.5. Амгалан өртөө



Төмөр замын нийт шугамын дагуу 120м, өртөөнүүдийн 2000м урттай хэсгүүдэд 300м өргөн зурвас газрыг УБТЗ ХНН-т өмч болгон шилжүүлсэн. Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтын энэ газарт газар ашиглах асуудал ноцтой зөрчил үүсгэж байгааг анхаарч төлөвлөлтөнд тусган шийдвэрлэх шаардлагатай.

❖ **Тээвэр зуучийн байгууллагууд болон Улаанбаатар хотноо ажиллаж байгаа терминалуудын хүчин чадал**

Тээвэр зуучийн байгууллагууд: Эдүгээ 40 гаруй үндэсний компани, гадаадын тээвэр зуучийн 15 орчим байгууллагын төлөөлөгчийн газрууд үйл ажиллагаа явуулж байдаг.

Төмөр замаар тээвэрлэх импортын тээврээр их хэмжээгээр, бөөнөөр тээвэрлэдэг задгай болон нурмаг ачааг вагоноор, бусад ачааг их даацын 20, 40 т чингэлгүүдээр тээвэрлэж байна.

Экспортын тээвэрт ихэвчлэн уул, уурхайн бүтээгдэхүүн, малын гаралтай боловсруулсан түүхий эд зэрэг ачааг тээж байна.

2005-2011 онд чингэлгээр тээвэрлэсэн ачаа эргэлт 767,9 буюу бараг 2 илүү дахин өссөн байна.


Тээвэр зуучийн 10 орчим терминаль, ДЦС-ын нүүрс буулгах 3 терминаль, Толгойтын нүүрсний талбай болон бусад агуулах зэрэг 18-19 ачаа тээврийн цэгүүд байна.

2005-2011 онд чингэлгээр тээвэрлэсэн ачаа эргэлт 767,9 буюу бараг 2 илүү дахин өссөн байна


Дүрслэл 5.1.4.1.6. Улаанбаатар хотын ачиж буулгах терминалуудын байршил



Дүрслэл 5.1.4.1.7. Тээвэр зуучийн компани



Дүрслэл 5.1.4.1.8. Чингэлэгтэй ачаа



Тээвэр зуучийн 10 орчим терминаль, ДЦС-ын нүүрс буулгах 3 терминаль, Толгойтын нүүрсний талбай болон бусад агуулах зэрэг 18-19 ачаа тээврийн цэгүүд байна.

Ачаа тээврийн хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж байгаа бөгөөд ачилтын 85-93 хувь, буулгалтын 75-85 хувь нь, экспорт, импортын ачааны 85 орчим хувь нь Улаанбаатарт төвлөрч байгаагаас үйлчилгээний чанарт нөлөөлөх болсон байна. Энэ нь чингэлэг, импорт, экспортын ачааны төрөлжилт хангалтгүйгээс ялгалт, ангилалт хийгдэх ачиж буулгах цэгүүдийн байрлал

өртөөнөөс алс, авто замын нөхцөл муугаас чингэлгийг хүргэхэд авто замын хөдөлгөөний түгжрэл зэрэг шалтгаанууд нөлөөлдөг.

❖ **Улаанбаатар зангилаа ба замын нэвтрүүлэх чадварын хязгаарлалт**


Төмөр замаар тээвэрлэх ачаа тасралтгүй нэмэгдэж байгаа нь 2011 онд 18.4 сая тонн ачаа тээвэрлэсэн байдлаас тодорхой байна. 2010 оны байдлаар төмөр замаар тээвэрлэсэн дамжин өнгөрөх ачаа 100 хувь, экспортын ачааны 85 хувь нь Улаанбаатараар дамжин өнгөрсөн байна. УБТЗ-ын хэтийн төлөвийн тооцоогоор 2015 онд 33.5 сая, 2020 онд 50.0 сая тонн хүрэх таамаглал байна. Энэ зорилтод хүрэхэд гол замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай боловч төмөр замын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл, гол замын газар зүйн байршил, авто замын хөдөлгөөний хүндрэлтэй байдал зэрэг нь боломжийг алдагдуулж байна.

- Улаанбаатар зангилаанд: Нэгдсэн терминаль байгуулах бодлогын хүрээнд салаа замуудыг татан буулгах, гол замтай огтлолцсон авто зам дээгүүр, доогуур гүүрэн гарц байгуулах, төмөр замын аюулгүй зурвасын газрыг чөлөөлөх,
- Гол шугам замд: Эмээлт, Хоолтын давааны огцом тохойрлуудыг шулуутгах, УБ зангилааны ачааллыг хөнгөвчлөх, хотын нутаг дэвсгэрийн хөрсний бохирдол, дуу шуугиан, хөдөлгөөний аюулгүй байдал зэрэг нөхцөлөөс шалтгаалан Рашаант өртөөнөөс Улаанбаатарыг алгасан Богдхан уулын урдуур Багахангай хүртэл шинэ төмөр зам тавих,
- Үүний зэрэгцээ төмөр замын зорчигч, тээвэр зуучийн байгууллагууд, зүтгүүрийн депо, суудлын вагон депо, ачих буулгах тээвэр- экспедицийн механикжсан анги замын II анги, зам засварын машинт станц зэрэг томоохон аж ахуй нэгжүүд ихээхэн зай талбай эзэлж, олон арван зам өдөр шөнө тасралтгүй ажиллаж Улаанбаатар хотыг хоёр хувааж байгаа нь хотын бүхий л үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа учир нарийвчлан судалж зарим байгууллага аж ахуйг хотоос гаргах,

5.2. Зам, тээврийн сүлжээ

❖ **Монгол улс, олон улсын тээврийн сүлжээнд холбогдох байдал.**

❖ **Дүрслэл 5.2.1. Азийн автозамын сүлжээ**



Транссибирийн төмөр замын магистраль, “Брест-Москва-Новосибирск-Улаан-Үүд-Чита-Находка” үүнээс салбарласан Забайкальск, Хятад улстай хиллэсэн, Наушкаар

дайран-Орос*Монгол-Хятад улстай холбогдсон төмөр замаар Улаанбаатар хот нь Ази, Европ тивтэй төмөр замаар холбогддог.

Олон улсын автозам.

- АН3 автозам нь ОХУ-ын Эрхүү - Улаан Үүд – Хиагт, Монгол улсын Алтанбулаг - Дархан - Улаанбаатар - Налайх - Чойр - Замын Үүд боомтыг дайран улсын хилээр нэвтэрч БНХАУ-ын Эрээн хот - Бээжин - Тяньжинь дах Тангу далайн боомт хүрэх автозам
АН4 автозам.
- БНХАУ-ын Шиньжан Уйгар мужийн Үрүмчи хотоос Такешикен боомт - Монгол улсын Ярантай – Ховд - Өлгий - Улаанбайшинтаар дамжин ОХУ-ын Ташанта – Барнаул - Новосибирск хүрэх зам
АН32 автозам.
- Улаанбаатарыг дайран манай улсыг зүүнээс нь баруун тийш хөндлөн өнгөрч байна.

Дүрслэл 5.2.2. Монгол Улсын олон улсын болон улсын чанартай автозамын сүлжээ



5.2.1. Хотын гадна зам тээврийн сүлжээ.


Транссибирийн төмөр замын магистральный салбарласан Монгол улсаар хойноос урагш дайран гарсан төмөр зам, АНЗ босоо тэнхлэгийн автозам, мөн АН32 хэвтээ тэнхлэгийн автозамууд нь Монгол орны төвийн бүс тухайлбал нийслэл хотоор дайран гарч байна. Түүнчлэн мянганы замын босоо тэнхлэгийн АН-3, хэвтээ тэнхлэгийн АН-32 дугаарын асфальт болон бетон хучилттай зам Налайх хотыг дайран өнгөрч байна.

Босоо тэнхлэгийн АН-3 замын Алтанбулаг-Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Чойрын 584 км-ийн хатуу хучилттай зам ашиглалтад орсон, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 425 км хатуу хучилттай зам 2013 онд ашиглалтад бүрэн орно.

Монгол улсын хүн амын шилжих хөдөлгөөнийг тогтворжуулахын тулд баруун, зүүн бүсийн хүн амыг зах зээл, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээгээр өнөөгийн Улаанбаатар хоттой адил хангах үүрэгтэй “хөгжлийн стратегийн төв”-ийн байршлыг зам, тээврийн сүлжээ, усны нөөцтэй уялдуулан оновчтой тогтоон хөгжүүлэх шаардлагатай байна Монгол улсын төрөөс хүн амын нутагшилт, суурьшлын дээрх асуудлыг бодлогын төвшинд авч үзэн “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д суурилсан хүн амын нутагшилт, суурьшлын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдийг боловсруулж УИХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажлыг яаралтай эхлэх хэрэгтэй байна.

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол улсын эдийн засаг, улс төрийн гол төв учир хотын дотор болон дагуул хот суурингууд бүсийн тулгуур төв хотууд, Монгол орны өнцөг бүрт, дэлхийн зах зээл хүрсэн, тээврийн сүлжээгээр найдвартай холбогдох нь чухал ач холбогдолтой. Эдгээр тээврийн сүлжээ нь агаарын зам, төмөр зам, авто зам тул эдгээрийг цаашид улам хөгжүүлэх шаардлагатай байна. Гадна зам, тээврийн сүлжээ нь агаарын зам, төмөр зам, авто зам гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Дүрслэл 5.2.1.1 Гадна замын сүлжээ. Одоогийн байдал



Автозамын тээвэр. Монгол улсын нийт сүлжээний урт 49250 км урт, үүнээс 11214 км нь улсын чанартай, зам байна.

Төмөр замын тээвэр. Төмөр замын нийт урт 1815 км, Монгол улсын хойд-урд хилийг холбосон гол шугам, үндсэн 2 шугамаас бүрдэнэ. Төмөр зам нь 1,520 мм-ийн өргөн цариг дан замтай бөгөөд Монгол, Хятадын хооронд хийх тээвэрлэлтэд Замын-Үүд боомтод ачаа шилжүүлэх шаардлага гарна.


Төмөр замын гол шугамын нэвтрүүлэх чадварыг боогдуулж буй ноцтой хязгаарлалт нь ачаа, зорчигч тээврийн ажлын зонхилох хувь нь төвлөрсөн Улаанбаатар зангилаа, хотын хоёр талаас орж ирж байгаа замын хэсгүүдийг хамарсан багалзуур болж байна. Үүнээс шалтгаалж олон сөрөг үр дагаврууд гарч байна.

Агаарын тээвэр. Агаарын тээвэр нь манай орны эдийн засаг, хүмүүсийн амьдралд чухал ач холбогдол бүхий нэг төрөл билээ. Улс орон хөгжин нээлттэй болохын хэрээр зорчигч болон ачаа тээвэрлэлтийн урсгал нэлээд нэмэгдэж байна. Цаашид манай оронд, тэр тусмаа Улаанбаатарын бүсэд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлснээр жуулчны тоо нэмэгдэж, манай оронд ирэх зорчигч тээврийн урсгал нэмэгдэнэ. Одоогийн байдлаар дотоодын нислэгийг хэд хэдэн үндэсний аж ахуйн нэгжүүд, олон улсын нислэгийг гадаадын болон дотоодын аж ахуйн нэгжүүд тус тус гүйцэтгэж байна. Хотын төвөөс 20 орчим км-ийн зайд орших, одоо ашиглагдаж буй “Чингис хаан” нисэх буудлын үйл ажиллагааг хэвээр хадгалж, цаашид орон нутаг, тусгай зориулалт болон

бизнес ангилал, ачаа тээвэр, сургалтын болон нисэхийн ачаа тээврийн терминалийн зориулалтаар ашиглах боломжтой.

Налайх, Багахангайн хуучин цэргийн зориулалт бүхий нисэх онгоцны буудлуудыг сэргээн засварлаж, зориулалтыг нь бизнес, үйлчилгээний зориулалт бүхий жижиг нисэхийн үйлчилгээ болгон өөрчлөх боломжтой.

Дүрслэл 5.2.1.2. Гадна тээврийн сүлжээ. Одоогийн байдал



Нийтийн зорчигч тээвэр.


Автозамын тээвэр. Улаанбаатарын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Улаанбаатар-361-ийн гарам, Улаанбаатар-Шувуу, Улаанбаатар-Өлзийт, Улаанбаатар-Налайх-Багануур, Улаанбаатар-Налайх--Багахангай, Улаанбаатар-Гачуурт гэсэн үндсэн чиглэлүүдээр Улаанбаатар хот нь бүсийн хот тосгодтой хатуу хучилттай авто зам, нийтийн зорчигч тээврээр холбогдсон.

5.2.2. Улаанбаатар хотын гудамж, замын сүлжээ

Авто зам нь хот байгуулалтын анхдагч хүчин зүйл болохын зэрэгцээ зохистой газар ашиглалтыг бүрдүүлдэг. Иймээс хотын өсөлт, газар ашиглалтын менежментийн бодлого тодорхойгүй нөхцөлд автозамын сүлжээг хөгжүүлэх стратегийг тодорхойлоход хүндрэлтэй ч хот төлөвлөлт, тээврийг иж бүрэн хөгжүүлэх бодлогын хүрээнд өсөлтийн менежментийг төгөлдөршүүлэх боломжтой. Хотын болон бүс нутгийн аль алины хувьд автозамын сүлжээний ангилал, зэрэглэлийн ашиглалтын горим алдагдсан, гудамжны улаан шугамын газар ашиглалт зориулалтын дагуу бус байгаа зэргээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөн холилдож зам тээврийн хөдөлгөөний түгжрэл, замын насжилтанд хүндрэлтэй асуудлууд хуримтлагдсан байна. Улаанбаатар хотын замын нөхцөл байдал дээрх байдлаас хамааран дараах бэрхшээлүүдийг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд.

- Замын үндсэн бүтэц ялангуяа хотын төв хэсгийн замууд 4-6 эгнээтэй, үндсэн байгууламж бүхий замын сүлжээтэй боловч замын чанар, замын байгууламжуудыг стандартад нийцүүлэх,
- Гудамж замын менежментийн төрөл бүрийн байгууламжууд ус зайлуулах, гэрэлтүүлэг, явган хүний зам, тусгаарлах зурвасыг гэнэтийн осол аюулаас сэргийлэх нөхцөлд нийцүүлэн сайжруулах,
- Хотын төвийн гол зам, туслах замуудын хоорондын холбогдсон байдал, эргэлт, үзэгдэх орчин, явган хүний замын хөдөлгөөний уялдаа, авто зогсоолын байрлал зэргийг төлөвлөлтийн норм, стандартад нийцүүлж аюулгүй байдлыг хангах.

Дүрслэл 5.2.2.1. Улаанбаатар хотын гудамж, замын сүлжээ /Одоогийн байдал/



2007 оноос хойш автозамын засвар шинэчлэлтийн ажилд дорвитой өөрчлөлт гарч улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар шинээр 8 зам / 11,47 км урт /, 16 замд өргөтгөл шинэчлэлт / 24,70 км /хийж автозамын хүчин чадлыг нэмэгдүүлсэн.

Одоогоор ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хурдны тойруу замууд, тэдгээрийг холбосон босоо замуудыг барих судалгааны ажлууд хийгдэж байна. Нарны зам /Тээвэрчдийн гудамжны өргөтгөл/-ыг иж бүрнээр хийж ашиглалтад оруулсан ба Баянголын амны автозамыг хатуу хучилттай болгосон.

5.2.2.1. Замын сүлжээний нэвтрүүлэх чадвар

Авто зам, замын байгууламжуудын судалгаа: Улаанбаатар хотын автозам, замын байгууламжийн бүртгэл, чанар байдлын нэгдсэн мэдээлэл байхгүй тоо хэмжээ зөрөөтэй байгаа байдал нь судалгаанд ихээхэн хүндрэл учруулсан. “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04 –д заасан ангиллын хүрээнд авто замын сүлжээг авч үзвэл 2010 оны байдлаар гол зам, туслах гудамж зам, нутаг дэвсгэрийн ангиллын 629.9 км зам байгаа бөгөөд гудамж замуудын зорчих хэсэг 6-22 м-ийн өргөнтэй, 1-2 урсгал, 2-6 эгнээтэй байна.

Нийслэлийн Автозамын газрын судалгаагаар 132.3 км гол гудамж, зам, 216.6 км туслах зам, орон сууцны хорооллын доторх зам 280.9 км буюу 648.5 км байна.

Мөн 3524,4 ум 56 ширхэг төмөр бетон гүүр байгаа бөгөөд автозамын 52 хувь нь 1985 оноос өмнө баригдсан 25-аас дээш жилийн насжилттай байна. 25 буюу түүнээс дээш насжилттай гүүр нийт 25 ширхэг буюу 1500 ум байна.

Хүснэгт 5.2.2.1.1. Автозамын ангилал

№	Замын ангилал	Тоо хэмжээ, км	Тайлбар
1	Гол гудамж зам	132.3 км	
2	Туслах гудамж зам	216.6 км	
3	Нутаг дэвсгэрийн зам /орон сууцны хорооллын доторх зам/	280.9 км буюу 1823км ²	
4.	Гүүр	56ш, 3524,4 ум	
Нийт дүн:		648.5	

Хотын замыг ашиглалтын насжилтаар авч үзвэл:

1-5 жил	- 5%
5-10 жил	- 5%
10-15 жил	- 10%
15-20 жил	- 24%
20-25 жил	- 2%
25-аас дээш жил	- 54%

1998 онд Улаанбаатар хотын авто замын мастер төлөвлөгөөний /2020он/ ТЭЗҮ-ийн судалгааны хүрээнд хийсэн үнэлгээгээр судалгаанд хамрагдсан барилгажсан хэсэг дэх 227 км урт 82 авто замын 20 км нь муу үнэлгээтэй, хот доторх 32 гүүрийн 3 гүүр нь урьдчилан хүчитгэсэн ТБ хийцтэй, ихээхэн эвдрэлтэй 4 гүүр байсан бөгөөд зам, замын байгууламжийн ихэнх нь 1960-1980 онд баригдсан байна. Мөн судлагдсан 10 уулзварын 6 нь аюулгүйн тойрогтой, III хорооллын болон Гэсэр сүмийн аюулгүйн тойргийг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн.

Автозамын гүүрийн байдал: Улаанбаатар хотын авто замын тооллогын дүнгээр 48 гүүр бүртгэгдсэний хүчитгэсэн ТБ дам нуруутай гүүр-2, ТБ дам нуруутай гүүр 38, ган дам нуруутай гүүр 1 байна.

Уулзвар, гарц: Улаанбаатар хотын хэмжээнд 100 орчим уулзвар байгаагийн 68 нь гол уулзвар бөгөөд 43 нь дохиололтой байна. Уулзвар нь хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд хөдөлгөөний эрчим нэмэгдэх тусам зөрчил үүсэх нөхцөлийг нэмэгдүүлж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чадвар нь буурдаг байна. Энэ тохиолдолд өөр түвшинд огтолцдог уулзвар, гүүрэн гарц байгуулах замаар шийдвэрлэнэ.

5.2.2.2. Авто замын хөдөлгөөний эрчим

Явган зорчигчдын хөдөлгөөн: Улаанбаатар хотын хүн амын, автомашины өсөлтөөс шалтгаалан авто зам, нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол, авто машины зогсоол, явган хүний замын хөдөлгөөний зохицуулалт алдагдаж явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн замын хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж явган зорчигчийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай байгууламжууд үгүйлэгдсээр байна.

Хотын суурьшлын бүс доторх явган хүний хөдөлгөөн, замын тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохио, газар дээрх болон доорх гарцын харилцан уялдаа нь явган хүний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байх шаардлагатай бөгөөд сүүлийн жилүүдэд хот төлөвлөлт, норм стандартыг харгалзах асуудал орхигдож байгаа байдлыг засч залруулах шаардлагатай болсон. Сүүлийн жилүүдэд замын хөдөлгөөний ачаалал

тасралтгүй нэмэгдэж 1998-2010 оны хооронд хөдөлгөөний эрчим 2 гаруй дахин нэмэгдсэн нь хотын өсөлтийг нотолж байна. Зорчилтын дундаж хурд төв замуудад 1998 онд 30-40 км/цаг байсан бол, 2007 онд 20-25 км/цаг буюу түүнээс доогуур хэмжээнд болж буурчээ. Улаанбаатар хотод автобус, троллейбус, микроавтобус, такси зэргийг оролцуулан нийт 1574 нийтийн тээврийн хэрэгсэл өдөрт үйлчилгээнд гарч байгаа бөгөөд тээврийн эрэлт хэрэгцээ явган зорчилтыг оруулбал 3,4 сая /зорчилт өдөр, явган зорчилтыг оруулахгүй бол 2,3 сая/ өдөр болж байна. Эрэлтийн бүтцийг авч үзвэл:

- Явганаар - 30,6%
- Автомашинаар - 24,2%
- Автобусаар - 33,4%
- Таксигаар - 9,2%
- Бусад тээврийн хэрэгслээр - 2,6% тус тус зорчиж байна.

Зорчилтын дийлэнх нь “хувийн ажлаар”-29,4% “ажилдаа 16,1%,”сургуульдаа” -9,0%, “гэрлүүгээ” -42,2%,”бизнесийн” -3,9% гэсэн зорилготой байна. Унадаг дугуй, мотоцикль, болон хувийн автобус /компани, сургуулийн г.м / -н хэрэглээ бага байна. Хүн амын бүх давхаргын хувьд такси нийтлэг унаа болж байна.

- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, нэгдмэл байдал эрхзүйн зохисгүй тогтолцооноос үүдэн алдагдаж, олон эзэнтэй болсноос байгаль экологи сүйрэлд хүрч, хот байгуулалтын бодлого алдагдсан. Тусгай хамгаалалттай газар нутаг БОЯ-ны мэдэлд, байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудал ЭБЭХЯамны мэдэлд, инженерийн шугам сүлжээгүй газар, дүүргийн Засаг даргын мэдэлд, шинэ хот, хорооллын барилгажилтын асуудал газрын албаны эрх мэдлийн хүрээнд гэх мэтээр зохицуулагдаж байгаа нь хариуцлагыг цалгардуулж эзэнгүйдүүлж байна.
- Хот суурингийн оршин тогтох үндэслэл болсон усыг 6 яам тухайн чиглэлээрээ хариуцаж байгаа нь усны бодлого, менежмент, засаглал алдагдаж, ус олборлолт, борлуулалтын мэдээ, мэдээлэл зөрүүтэй, нэгдсэн менежментгүй, хэт хуучин технологи, хуучин алдаатай бодлогын үр дүнд зохисгүй менежментийн улмаас хомсдолд орж, хот байгуулалт, төлөвлөлтөнд ганцхан гүний ус ашиглан, гадаргын усыг ашиглах судалгаа тооцоог мэргэжлийн түвшинд хийж ТЭЗҮ-г боловсруулаагүй гадны байгууллага хүмүүсийн санал төдий байгаа болон төв цэвэрлэх байгууламж нь цэвэршүүлсэн усыг олон дахин ашиглах асуудлыг шийдээгүй, технологийн сонголт хийж, туршин норм, стандарт батлуулаагүй, гадны үнэ хямд, хуучин технологийн туршилтын талбар болгон үр ашиггүй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, өрөнд орсоор байна.

Дөрөвдүгээрт: Ерөнхий төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт зохих хэмжээнд хийгдээгүй.

- Өнгөрсөн 10 жилийн хугацаанд улс, орон нутгийн төсвөөс нийтдээ 800 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Энэ хөрөнгөний 680 орчим тэрбум нь сүүлийн 5 жилд хийгджээ. Энэ хөрөнгө нь үндсэндээ сая гаруй хүн амтай их хотын жил жилийн их засвар үйлчилгээнд ихэнх нь зарцуулагдсан байна. Гэтэл ерөнхий төлөвлөгөөний шинэ бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд 1 жилд хамгийн багадаа 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийх шаардлагатай байсан.

VIII БҮЛЭГ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГО

8.1. Хот байгуулалтын талаар

Монгол улсын төрөөс улс, орны хөгжлийн бодлогын талаар баримталж буй бодлого нь урт, богино хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлсон дараах баримт бичгүүдэд тусгагдан хэрэгжиж байгаа боловч хүн амыг нутаг дэвсгэрт оновчтой нутагшуулж суурьшуулах, үүнтэй холбогдож үүсэх олон асуудлуудыг шийдвэрлэж эхлээгүй ялангуяа Монгол улсын өнөөгийн хөгжлийг ганц Улаанбаатар төвт тогтолцоонд уялдуулан зохицуулж байгаа нь бүсүүдийн тэнцвэртэй хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна.

❖ *Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*

Монгол улсын нийгэм, эдийн засгийн шилжилтийн үе дууссан эрчимтэй хөгжлийн эхэн үед дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Монгол улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг боловсруулсан байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогыг дараах үндсэн зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

1. Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж монгол хүнийг бүх талаар хөгжүүлэх,
2. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглаж, хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй өндөр хөгжлийг хангаж, орчин үеийн боловсруулах салбарын үйлдвэрийг хөгжүүлэх,
3. Экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох,
4. Бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах.
5. Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалан ашиглах замаар хөгжлийн тогтвортой орчин болгох,
6. Улс төрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, үйл ажиллагаа нь шуурхай бөгөөд хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлэх

Монгол улсын МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх үе шат:

- ❖ Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат буюу 2007-2015 он,
- ❖ Мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үе шат буюу 2016-2021 он

Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат буюу 2015 онд МХЗ-ууд бүрэн хэрэгжсэнээр:

- Хөгжлийг түргэтгэх үндсэн салбарын стратегийн орд газруудыг цаг алдалгүй эдийн засгийн эргэлтэнд оруулж, хуримтлалыг бий болгож нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хөгжлийг эрчимжүүлэх, нийт ард түмний амьдралыг сайжруулж ядуурлыг 2 дахин бууруулах,
- Эдийн засгийг жилд 14-өөс доошгүй хувиар өсгөх, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний одоо байгаа нэг мянган ам.долларыг 5 мянган ам.доллараас доошгүй түвшинд хүргэх,
- Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг мэдэгдэхүйц багасгах үндэс дэд бүтцийн салбарын хөгжлийг тэтгэж хатуу хучилттай авто замыг 8000 км-т хүргэх,
- Говийн болон зүүн бүсэд төмөр зам барих ажлын 60-аас доошгүй хувь, хоёр дах төмөр зам барих ажлын 70-аас доошгүй хувийг барих, гол төмөр зам, бүх сумд цахилгаан эрчим хүчээр хангагдаж нар, салхины эрчим хүч хэрэглэнэ, эрчим хүч экспортолж эхэлнэ,
- Иргэдээ орон сууцаар хангах асуудлын хүрээнд улсын хэмжээнд жилд дунджаар 100000-аас доошгүй өрх орон сууцны нөхцөлөө сайжруулах, бүсийн тулгуур төвүүдийг 50000-аас доошгүй хүн амтай орчин үеийн хотууд болгож хөгжүүлэх, нийслэлийн гэр хорооллын 30 мянгаас доошгүй өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох,

- Эрчимтэй хөгжлийг тогтвортой болгох, технологи нэвтрүүлж мэдлэгт суурилсан эдийн засагтай болох гол арга механизм боловсролын салбарыг чанаржуулах, олон улсын жишигт нийцсэн 10-аас доошгүй ЕБСургууль, хоёроос доошгүй их сургуультай болох,
- Хөгжлийг тогтвортой болгох цаг уурын огцом өөрчлөлт, цөлжилтийн сөрөг үр дагаварыг багасгахын тулд экосистемийн тэнцвэрт байдалд анхаарч тусгай хамгаалалттай газар нутгийг нийт нутаг дэвсгэрийн 20-иос доошгүй хувь буюу 30 гаруй саяд хүргэх ,

Хоёр дах үе шат буюу Мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үед үндсэн дараах зорилтод хүрэхээр тусгасан. Энэ үед манай улсын эдийн засаг нэгэнт авсан хурдаа сааруулалгүй жилд дунджаар 12-оос доошгүй хувиар өсч ДНБ 12 мянгаас доошгүй ам.долларт хүрч, оюуны шингэц бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, мэдлэгт суурилсан эдийн засаг төлөвшин хөгжиж, Монгол улс дэлхийн дундаж орлоготой орнуудын эхэнд багтана. Энэхүү хүрэх түвшинг Азийн бусад орнуудтай харьцуулбал Өмнөд Солонгос улстай ижил түвшинд очно гэсэн үг юм.

Энэ үе шатны маш чухал зорилт нь ашигт малтмалын олборлолтоос бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шилжих явдал бөгөөд боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, шинэ технологи нутагшуулсан эдийн засаг руу шилжинэ гэж тооцсон.

- 2021 он гэхэд ядуурлын асуудал бүрмөсөн шийдвэрлэгдэж нийгэмд харьцангуй чинээлэг дундаж давхарга бүрэлдэн төлөвшиж баян ядуугийн ялгаа арилна.
- Хүн бүрт ижил тэгш боломж, бололцоо олгодог орчин бүрдэн төлөвшсөнөөр орон сууцны хангамжид үсрэнгүй ахиц гарч шаардлагатай үедээ айл, өрхүүд орон сууцны нөхцөлөө сайжруулдаг болно.
- Хот байгуулалт, бүсийн хөгжлийн бодлого хэрэгжиж бүсийн тулгуур төв хотуудын хүн ам тус бүр 100 мянгад хүрч орон нутагтаа тогтвор суурьшилтай амьдрах таатай орчин бүрдэнэ.
- Боловсролын салбар олон улсын стандартад ойртсон хөтөлбөртэй байсан бол “нийцсэн” хөтөлбөртэй болно. Эрүүл мэндийн салбарт онцгой ахиц гарч олон улсын жишигт нийцсэн оношилгоо-эмчилгээний төвүүд байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрнэ.
- Эдийн засгийн хараат байдлаас гарч нефтьийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс хангана.
- Дэд бүтцийн хөгжил бол хөгжлийг түргэтгэх чухал салбар. Ази тив, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай орчин үеийн тээвэр, холбоо, эрчим хүчний дэд бүтцийг бий болгож хатуу хучилттай замыг 11000 км-т хүргэнэ. Баруун, Зүүн, Говийн бүс дэх төмөр замын сүлжээ бүрэн байгуулагдана. Хоёр дахь төмөр зам ашиглалтанд орно.
- Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, жилд ирэх жуулчдын тоо хүн амын тоотой тэнцэнэ.

Даяарчлалын үед дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг тооцож бүс нутгийнхаа улс төр, эдийн засгийн уялдлагаанд идэвхтэй оролцогч улс, орон нутгийн түвшинд цогцоор авч үзэх шаардлага тулгарч буй энэ цаг үеийг мэдэрч боловсруулсан Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын баталгаа, Монгол улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого болон Хүн ам нутагшилт суурьшлын ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэг **“Монгол улсын эдийн засаг, нийгэм, хот байгуулалтын хөгжлийн төрийн бодлого”**-ын баримт бичгүүдийн нэгдмэл үзэл баримтлалыг үндэслэн нийслэл хотын хөгжлийн бодлогыг тодорхойлох нь цаг үеийн хэрэгцээ шаардлага болж байна.

❖ **Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал**

Монгол Улсын Их хурал 2001 онд “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг, 2003 онд “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги /2010 он/, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль”-ийг тус тус баталсан.

Стратеги нь: Хүнээ эрхэмлэн дээдэлсэн, байгаль орчны онцлогт зохицсон, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой, өндөр технологид суурилсан үйлдвэр, үйлчилгээ бүхий эдийн засгийн бат суурьтай болж, хөгжсөн орнуудын нийслэл хотуудын жишигт хүрсэн бүс болгоход чиглэсэн.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан

оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутгийн хоорондын тэгш бус, тэнцвэртэй байдлыг багасгаж, хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчин бүрдүүлэх асуудлыг эрхэм зорилго болгон Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн эдийн засгийн 4 бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр 5 дахь бүс болгон хөгжүүлэхээр тусгасан.

Бүсүүдийн нутаг дэвсгэрийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан үзэж хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсны дагуу Улаанбаатарын бүсэд оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк, санхүүгийн сүлжээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр тусгагдсан.

Улаанбаатарын бүсийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөрийн эхний үе шатны зорилтын хэрэгжилт 2011 оны байдлаар дунджаар 84,1 хувьтай байна.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ 2006- 2009 онд 8 дахин нэмэгдэн, улмаар 2010 онд нийслэлийн төсөв өмнөх оноос 50 хувиар өсч, хөрөнгө оруулалтын хэмжээ 1,3 дахин нэмэгдэн 209,6 тэрбум төгрөгт хүрсэн нь Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд зохих дэмжлэг болсон ч шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Хүснэгт 8.1.1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын нэр төрөл	2006	2007	2008	2009	2010
Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сан, бүс орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт /тэрбум төг/	11,78	11,8	134,7	138,2	180,8
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт /тэрбум төг/	8,76	17,1	13,7	19,2	28,8
Нийт хөрөнгө оруулалт /тэрбум төг/	20,54	28,9	148,4	157,4	209,6

2011 онд нийслэлд 219,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэхээр тусгагдсан нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад ихээхэн түлхэц болно.

Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат дуусахад буюу 2010 оны эцэст эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэж, дотоодын нийт бүтээгдэхүүн дунджаар 7,5 хувиас доошгүйгээр тогтвортой өсөхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, бүсийн эдийн засагт орчин үеийн үйлчилгээ, боловсруулах аж үйлдвэр, аялал жуулчлалын салбар тэргүүлэх байр суурийг эзэлж, зарим дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдаж, мэдлэг, мэдээллийн технологид суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдана хэмээн тооцоолсон.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шатанд бүсийн ДНБ-ний үйлдвэрлэлийг жилд дунджаар 7,5%-иас дээш тогтвортой өсгөж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс тавих, үйлчилгээнд өндөр технологи нэвтрүүлэх, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний тогтвортой өсөлтийг хангаж бүсийн эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох зорилт тавьсан. Хэрэгжилт 86.4 хувийн дундаж биелэлттэй.

Улаанбаатар бүсийн ДНБ-ний талаар авч үзвэл Монгол улсын 2009 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 50.5 хувийг Улаанбаатар хот бүрдүүлжээ. Нийслэл хотын эдийн засаг 2009 оны үнээр 3058.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 0.4 хувиар өссөн байна.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 50.3 хувийг Улаанбаатар хот 2000 онд бүрдүүлж байсан бол 2008 онд 54.0 хувь болж 3.7 пунктээр өсч, харин 2008 онд 50.5 хувь болж, 2004 оныхоос 3.5 пунктээр буурсан байна. Улсын ДНБ-ний дүнд Улаанбаатарын эзлэх хувь хэмжээ буурч байгаа нь Орхон, Сүхбаатар зэрэг бусад аймгийн нэмүү өртгийн хэмжээ өсч байгаагаас голлон шалтгаалжээ.


Нийслэл хотын эдийн засгийн 68.4 хувийг үйлчилгээний, 30.5 хувийг үйлдвэрлэл, 1.1 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлдэг. ДНБ-ний салбарын бүтцийг бүсээр харьцуулбал, баруун бүсэд хөдөө аж ахуй, хангайн бүсэд үйлдвэрлэл, Улаанбаатарт үйлчилгээний салбар зонхилж байна.

Нийслэлийн нэг хүнд ноогдох нэмүү өртөг 2008 оноос 37.1 хувиар өсч, 2.9 сая төгрөг болжээ. Улсын дундажтай харьцуулахад нэг хүнд ноогдох нэмүү өртгийн хэмжээ даруй 657.9 мянга гаруй төгрөгөөр буюу 29.1 хувиар илүү байна.

Нийслэлийн хөгжлийн түвшний нэгдсэн индекс 0.521 байгаа нь улсын дунджаас 53.7 хувиар, Төвийн бүсээс 69.7 хувиар, Хангайн бүсээс 2 дахин их байна. Энэ нь нэг талаасаа Улаанбаатар бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсүүдтэй харьцуулбал өндөр байгааг харуулж буй ч нийслэлийн үүргийнхээ дагуу бусад бүсүүдэд үзүүлэх эдийн засгийн эерэг нөлөөлөл сул байгааг бас илэрхийлж байна. Нийслэлийн хувьд бусад аймаг, хөдөө орон нутгаас дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зэрэглэлээр харьцангуй өндөр түвшинд байгаа нь байгаль цаг уур, бусад хүчин зүйлээс болж амьжиргааны түвшин доройтсон, нийгмийн илүү чанартай үйлчилгээнд ойртох хүсэлтэй иргэдийн төвлөрөх цэг болж байна. Энэхүү хэт төвлөрлийн улмаас хотын эдийн засаг, хүний нөөцийн бүтцэд зохисгүй харьцаа бий болж, улмаар газар, үйлчилгээ, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэ огцом өссөн байна.

Улаанбаатар бүсийн бусад бүсүүдийн ДНБ-ний индекс тэй харьцуулсан харьцаа 2009 оны байдлаар 0.626 байгаа нь хамгийн бага Баруун бүсээс 1,4 дахин, хамгийн өндөр Хангайн бүсээс 1,03 дахин их үзүүлэлт юм.

Дүрслэл 8.1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, бүсээр /2009 он/



Үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувийн жин 16 хувиас 8 хувь болтол буурчээ. Бөөний болон жижиглэнгийн худалдаа, засварын үйлдвэрлэл хувийн хэрэглэгчдийн тусламж дэмжлэгтэйгээр явагдаж байна. Уул уурхайн үйлдвэрлэлд гадаадын шууд хөрөнгө оруулалт ихээхэн хэмжээгээр орох болсон, гадаадад ажиллаж буй монгол ажилчдаас бэлэн мөнгө ихээр гуйвуулж байгаа нь орон сууцны зах зээл болон айл өрхийн авто машины өсөн нэмэгдэж буй хэрэглээнд түлхэц болж байна.

Өнөөгийн байдлаар бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилгын үйлдвэрлэл Улаанбаатар хотын эдийн засгийг идэвхжүүлж байна. Нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг нийт 53138 аж ахуйн нэгж, байгуулга бүртгэлтэй бөгөөд үүнээс 26734 аж ахуйн нэгж жилийн турш тогтмол үйл ажиллагаа явуулсан байна.

Үйлдвэрлэл технологийн парк байгуулах чиглэлээр Багануур дүүрэгт, барилгын материал, шахмал түлш, төмөрлөгийн үйлдвэрлэл технологийн парк, Багахангай дүүрэгт мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл технологийн парк байгуулах, Хан-Уул дүүрэгт ХАА-н түүхий эдийг гүнзгий боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох бүрэн мөчлөг бүхий үйлдвэр технологийн парк байгуулах төсөл боловсруулах талаар захирамж шийдвэр гарч төслийг боловсруулан, хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ажлыг ханган, эхний ээлжинд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

❖ **Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр**

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь:

1. Хүн амын нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилтын хүрээнд гэр бүлийг тэтгэх, хүн амын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх оновчтой бодлогыг хэрэгжүүлж хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчинг бүрдүүлж иргэдийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх,
2. Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр боловсруулах, нутаг дэвсгэрийн геологи, ашигт малтмалын судалгаа хийх, үндэсний гео-мэдээллийн санг бүрдүүлэх, цөмийн эрчим хүчний судалгаа хийж ТЭЗҮ боловсруулах, стратегийн орд бүрээр төсөл боловсруулах, Говийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах замаар уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан ЖДҮ –ийг дэмжиж дэд бүтцийг сайжруулан МАА, газар тариалангийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгох, хүн амын шилжилт хөдөлгөөнийг бодлогоор зохицуулж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг арилгах, “Хотууд” үндэсний хөтөлбөр, Хөдөөгийн хөгжил хөтөлбөр боловсруулах, Ховд, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Замын-Үүд, Сүхбаатар хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгож хөгжлийн цогц арга хэмжээ авч хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлнэ,
3. Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилтын хүрээнд экосистемийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц баялгийг хамгаалах, усны талаарх төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, газрын талаарх төрийн бодлого, нэгдмэл сангийн оновчтой төлөвлөлтөнд үндэслэсэн газар түүний хэвлийн баялгийг ашиглан хамгаалах, нөхөн сэргээх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж газрын болон эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог өөрчлөн, газар зохион байгуулалт, газрын үнэлгээний аргачлалыг шинэчлэн мөрдүүлэх замаар хот, суурины хөрс, ус, агаарын бохирдлыг багасгах, хог боловсруулах үйлдвэр байгуулах цогц бодлогыг хэрэгжүүлж хөгжлийн тогтвортой орчинг бий болгож аялал жуулчлалын цогц бодлого хэрэгжүүлэх, ойн нөөц, амьтан ургамлын нөөцийг хамгаалах,
4. Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох үндсэн чиглэлийн хүрээнд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус ажиллах эдийн засаг, зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх, хил хамгаалах нэгдмэл тогтолцоог баталгаажуулах, улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж мэдээллийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төр- иргэний нийгмийн түншлэл, харилцан итгэлцлийг бэхжүүлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлж, төвлөрлийг сааруулах, удирдлагыг төрийн байгууламжид нийцүүлэн шинэчлэх, Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахад гадаад бодлогыг чиглүүлэх зэрэг улс, орны эдийн засаг, нийгмийн хөгжил, хүний хөгжилд чиглэсэн олон асуудлууд тусгагдсан байна.

Хөтөлбөрт тусгагдсан зорилтууд нь Монгол улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, хүн амын нутагшилт, суурьшил, тав тухтай, амгалан тайван, хангалуун амьдралын баталгаа болохуйц Хот байгуулалтын үндэсний бодлогод тулгуурласан аливаа улс, төр бизнесээс хамааралгүй, тасралтгүй бөгөөд залгамж чанарыг агуулсан хөгжлийн богино хугацааны баримт бичиг байлгахад анхаарах шаардлагатай нь дээрх хөтөлбөрийн агуулга, эрэмбэ дараалал, орон зай багтаамжаас тодорхой харагдаж байна.

❖ **“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр**

Монгол Улсын Их Хурал 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт хот байгуулалт, төлөвлөлт, дэд бүтэц, орон сууцны хангамж, ажлын байр нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, хөдөөгийн хөгжлийг дэмжих, үйлдвэржилтийг дэмжих, шилжилт хөдөлгөөний сааруулах талаар 2010-2012, 2013-2016 онд хот хөдөөд авч хэрэгжүүлэх олон чухал арга хэмжээ тусгагдсан.

2011 онд Хот байгуулалт, төлөвлөлтийн мэргэжлийн байгууллага байгуулж мэргэжилтэн бэлтгэж сургах, “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, бүсүүд, чөлөөт бүс,

хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах 115 хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, “Улсын, бүсийн, аймгийн, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, 4 хууль шинээр боловсруулж 2 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Улаанбаатар хотын гэр хорооллыг шинэчлэн зохион байгуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох бохирдол үүсгэгч 20 үйлдвэр, 9 онцгой объектыг нүүлгэх, их, дээд сургуулийн цогцолбор байгуулах зэрэг тулгамдсан олон асуудлууд тусгагдсан нь хүн ам, нутагшилт суурьшлын зохистой тогтолцоо бүрдэх зөв эхлэл болж байгаа болно.

Дэд бүтцийн зорилтын хүрээнд: Улаанбаатар хотод баригдах 75.0 мянган айлын орон сууц, бусад нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг цогцоор нь барихад зориулж Эрчим хүчний 5 дах эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулах, цахилгааны 110 кВт-н “Их тойруу” цагариг шугам сүлжээг байгуулах, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ийн үйлдвэрийн уурын нөөцийг дулаан үйлдвэрлэх зориулалтаар ашиглах, гэр хорооллын 2500 айл өрхийг төвлөрсөн дулаан хангамжид хэсэгчлэн холбох, төв цэвэрлэх байгууламжид тунгаагуур шинээр барих, Нисэх, Найрамдал, Биокомбинатын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх зэрэг арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар хот, аймаг, орон нутгийн ус хангамжийн эх үүсвэрүүдийн ашиглах боломжтой усны нөөцийг тогтоох, Сэргээгдэх эрчим хүчний нөөцийн нарийвчилсан судалгаа хийж, мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.

Авто замын сүлжээг сайжруулах зорилтын хүрээнд: 2012-2016 оны хооронд 5572 км авто замыг барьж бүх аймгуудыг нийслэл хоттой, Арцсуурь, Бургастай, Шивээхүрэн, Бага илэнх, Эрээнцав, Ульхан, Бичигтийн боомтуудыг аймгийн төвүүдтэй хатуу хучилттай авто замаар холбоно.

Улаанбаатар хотод 2010-2012 оны хооронд 41,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 104 км авто замыг барина.

Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 997 км хурдны зам, Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүдийг холбосон хурдны авто замыг ашиглалтад оруулснаар ОХУ ба БНХАУ цаашилбал Зүүн Европ, Сибирийн зах зээлийг Зүүн хойд Азийн зах зээлтэй холбосон авто тээврийн коридорт Монгол Улс нэгдэж орно.

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр нь харьцангуй орон зайн мэдрэмжтэй, хот, хөдөөд чиглэсэн тодорхой зорилтуудыг агуулсан, мэргэжлийн байгууллага, байгуулах, мэргэжилтэн бэлтгэх замаар бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх эхлэлийг тавьсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам нь, хэрэгжүүлэгч нь, оролцогч нь бүрхэг хөрөнгө оруулалт нь улс, орон нутгийн төсвөөс хараат учир хэрэгжилт удаашралтай, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх шаардлага анзаарагдаж байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд Хөгжлийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх арга замын эхлэл байгаа боловч харилцан шүтэлцээ, уялдааг хангах асуудал учир дутагдалтай байна.

8.2. Газрын харилцааны талаар

❖ Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2003 онд боловсруулахдаа Монгол Улсын хөгжлийн бодлогын 18 баримт бичиг, салбарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг харгалзан газар бүсчлэн хөгжүүлэх арга буюу нутаг дэвсгэрийг бүслэн төлөвлөх арга зүйг баримталсан байна. Төлөвлөлтийн хугацаа улсын ГЗБЕТ 16-20 жил, Нийслэл 12-16 жил байдаг. Мөн тухайн жилийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тухайн хот, тосгоны ИТХурал баталдаг.

Газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр газрыг бүсчлэн хуваарилах аргаар газрын бодлогын нийтлэг болон тодорхой бүсүүдийг гаргаснаар аймаг, нийслэлийн газрын талаар баримтлах бодлого тодорхой болж нь энэхүү газрын мененжментийн бүсийн хүрээнд газар зохион байгуулалтын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах үндэслэл болж байна.

Газрын нэгдмэл сангийн ашиглалтын түвшинг улс, эдийн засгийн бүс, аймаг, байгаль аж ахуйн нутаг дэвсгэрийн район бүрээр тодорхойлж түүний хэтийн өөрчлөлт, бүтцийг эдийн засгийн бүх

Цаашид газар зохион байгуулалтын төлөвлөлтийг хот төлөвлөлтийн үндсэн зарчимтай нийцүүлэн хот байгуулалтыг дэмжсэн газар зохион байгуулалтын бодлогыг тодорхойлох шаардлагын үүднээс хот суурины нутаг дэвсгэрийн бүсчлэл, газрын нэгдмэл сангийн ангиллын бүтцийг уялдуулан газрын үнэлгээг оновчтой тодорхойлж үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.


8.3. Хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт

Хөгжлийн бодлого, түүнийг төлөвлөх, тэдгээрийн тасралтгүй бөгөөд хараат бус байдал, хуульчлан хэрэгжүүлэх тогтолцоо харилцан уялдааг хангах асуудал учир дутагдалтай явж ирснээс хот, тосгоны хөгжлийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл тодорхойгүй урсгалаар явж зогсонги байдалд орсон нь хүн ам зах зээл, бараадаж тогтвортой суурьших газар олж ядан холхилдож нийгмийн үйлчилгээний давууг даган Улаанбаатар хотод төвлөрөх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй.

Улс, орон нутгийн хөгжлийн бодлого нь дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдан тодорхойлогдож байгаа боловч хот байгуулалтын талаар төрөөс баримталж буй нэгдсэн бодлого учир дутагдалтай байгаа байдал харагдаж байна.

Монгол улсын хот байгуулалтын бодлого нь Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүс нутгийн хөгжлийн төсөл, нийслэл хот, бүсүүдийн тулгуур төв хотуудын ерөнхий төлөвлөгөө зэрэг бүс нутаг, хот, тосгодын хөгжлийг тодорхойлох хот төлөвлөлтийн баримт бичгээр тодорхойлогддог.

Дүрслэл 8.3.1. Монгол улсын хот байгуулалтын зураг төслийн баримт бичиг



Сүүлийн жилүүдэд хот төлөвлөлтийн мэргэжлийн байгууллага байхгүй болж боловсон хүчин дутагдалтай болсон. Хот төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах дараалал, харилцан шүтэлцээ алдагдан, мэргэжлийн удирдлага, хяналтын тогтолцоо орхигдсоноос нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хот байгуулалтын бодлогоос салангид төсөөлөгдөж буух газаргүй агаарт, цаасан дээр төлөвлөгдөн улмаар улс орны хэмжээнд хот, тосгоны хөгжил, эдийн засгийн бие даасан байдал алдагдахад хүрсэн.

Хүн амын нутагшилтын зохистой тогтолцоог бүрдүүлж бүсүүдийн тогтвортой хөгжлийг ханган хот, тосгодын эдийн засаг, бүтээмжийг сэргээж, улс, бүс нутгийн болон орон нутгийн чанартай

шаталсан үйлдвэрлэл, үйлчилгээг том хотууд, бүс нутгийн төвүүдэд нэмэгдүүлснээр багтаамжаасаа хэтэрсэн нийслэл хотын хүн ам, үйлдвэр, үйлчилгээний бөөгнөрлийг бууруулна.

8.3.1. Төлөвлөлтийг хэрэгжүүлэх тогтолцоо

Улаанбаатар хот болон бусад хот, тосгодын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа Хот байгуулалтын тухай хуулийн хүрээнд явагдах ёстой.

Хуулийн 21 дүгээр зүйл: Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дараалалд:

- Хүн ам нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд дэд бүтцийг эхлэн барьж байгуулах гэж заасан.

Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж байгууллага, иргэний эрх, үүрэг:

- Хот байгуулалтын тухай хууль, норм дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөх, орчны бохирдлоос сэргийлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах,

Хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах болон хориглох зүйл:

- Түүх соёлын дурсгалт газар болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд, гол усны эрүүл ахуй хамгаалалтын бүсэд, байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай газарт, газар доорх болон дээрх дэд бүтэцтэй газарт.

Дүрслэл 8.3.1.1. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх тогтолцог




Улаанбаатар хот болон бусад хот, тосгодын хөгжлийн “бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хөрөнгө оруулалт”-ын уялдаа холбоо харилцан хамаарлыг хуульчлан тэдгээрийг эзэнжүүлж, хариуцлагжуулах аливаа улс төр бизнесээс хараат бус байлгах асуудал тулгамдсан гол асуудал болж байна.

8.4. Хууль эрхзүйн орчин, түүний хэрэгжилт, тулгамдсан асуудал

Нийслэл хотын хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах үйл ажиллагаа нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай, Барилгын тухай хууль, Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, Улаанбаатар хотын барилгажилтын түр дүрэм зэрэг эрх зүйн баримт үндсэн баримт бичгүүдийн хүрээнд зохицуулагдаж байна.

Дүрслэл 8.4.1. Хот байгуулалтын талаарх монгол улсын хууль тогтоомж



“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиар Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүнийг байгуулах, өөрчлөх татан буулгах, төсөв, удирдлагын тогтолцоо, нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо, харилцааг,

“Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулиар Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, түүний эдэлбэр газар, нийгэм эдийн засгийн үндэс, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад байгууллага, оршин суугчтай харилцах харилцааг,

“Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулиар нийслэл хот, түүний онцлог чиг үүрэг, нийслэлийн нутаг дэвсгэр, хотын эдэлбэр газар, нийслэлийн өмч, төсөв, нийслэл хотын оршин суугч, түүний үүрэг нийслэлийн удирдлага, эрх, байгууллага, иргэд хоорондын харилцааг,

“Хот байгуулалтын тухай” хуулиар монгол улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн ам, нутагшилт суурьшлын зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, байгууллага, иргэний харилцааны зохицуулалтыг,

“Барилгын тухай” хуулиар барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, техникийн хяналт тавихтай холбогдсон харилцааг, хуульчлан тодорхойлсон.

8.5. Удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо

❖ Улс, бүс нутгийн түвшинд

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд нийцсэн төрийн болон орон нутгийн бүтэц, орон тоо, удирдлагын тогтолцоо бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Улаанбаатар хотын хүрээнд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хяналт, удирдлага зохицуулалтын нэгдмэл байдал алдагдсанаас байгаль, экологийн аюул нүүрлэх үндэс болсон гэж үзэх үндэстэй байна. Хотын тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрын асуудал хотын хараа хяналтаас ангид байгаа бөгөөд нийгмийн хамгийн чухал зарим салбар эзэнгүй шахам тухайлбал хүн амын амьдралын анхдагч хэрэгцээ болсон усны асуудал, орон сууцны асуудлыг хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллага байхгүй, орон сууцны хангамжтай холбоотой барилгын материалын үйлдвэрийн бодлого, төлөвлөлтийн асуудал бараг эзэнгүй, хөл, гаргүй. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг УИХ батлахаар хуульчилсан боловч түүнтэй салшгүй холбоотой, түүнээс дутахааргүй ач холбогдол бүхий Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллага, улсын эксперт хийх эрхзүйн тогтолцоо байхгүй бөгөөд Нийслэлийн ИТХурал хэлэлцэн баталж байгаа нь нийслэл болон Улаанбаатар хотын, бүр түүнчлэн бүсийн нутаг дэвсгэрийн байгалийн нөхцөл, нөөцийг харгалзаж үзэлгүйгээр газрын харилцааг үүсгэж байна. Мөн түүнчлэн газрын үнэлгээний бүсчлэл, хот төлөвлөлттэй уялдаагүй байгаа нь газрын үр өгөөж, хяналтыг бүрхэгдүүлж байна.

Төрийн яамд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, орон нутгийн төрийн захиргааны бүтэц, зохион байгуулалт уялдаагүй тухайлбал газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал дээд байгууллагын түвшинд нэгдмэл байсан боловч хотод өөр, барилгын материалын үйлдвэрлэл, инженер геологи, газар хөдлөлийн асуудал орон нутагт эзэнгүй, авто зам, тээврийн асуудал бүр эмх замбараагүй болсон автозамын ачаа тээврийн асуудал эзэнгүй байгаа нь хотын нийтийн ахуй үйлчилгээ, эрүүл ахуйн нөхцөлд ихээхэн хүндрэл учруулж тулгамдсан асуудлуудыг хурцатгаж байна.

❖ Орон нутгийн түвшинд

Монгол улсын төрийн удирдлагын бүтэц зохион байгуулалт оновчтой бус зарим салбар, амин чухал асуудлууд эзэнгүйдсэн, зарим ажил үүрэг давхардсан зэрэг гаж тогтолцоо нь, хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулж дээр дооргүй хариуцлагын тогтолцоог сулруулж байна. Зөвхөн хот байгуулалт, газар ашиглалтын хувьд авч үзэхэд тусгай хамгаалалттай газар нутагт яам, ашигт малтмалтай газарт АМХЭГазар, инженерийн шугам сүлжээгүй газарт дүүрэг, шугам сүлжээтэй хэсэгт нийслэл газар эзэмших эрх олгож, эзэмшил газрын зориулалтын хүрээнд л барилгажилтын бодлого явагдах хууль эрхзүйтэй байгаа нь хот төлөвлөлт, хөгжлийн бодлогын цогц байдлыг бүрмөсөн алдагдуулж байна.

Сая гаруй хүн амтай хотын холбоо, эрчим хүч, дулаан хангамжийн асуудал яамны харьяалалд байгаа бөгөөд тусгай зориулалтын газар буюу батлан хамгаалах зориулалтын зэрэг газрууд дах барилга байгууламжууд өмчлөгдсөнөөс, газар эзэмших зориулалт алдагдаж ангилал шилжүүлэх асуудал одоо болтол шийдэгдэхгүй хотын мэдлээс ангид байдаг.

Үйлдвэрийн зориулалтын нутаг дэвсгэрийн асуудал туйлын хүндрэлтэй болсон үйлдвэрүүд хувьчлагдаж үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсноос зориулалтын бус үйл ажиллагаа явуулж хяналтаас гарч орчиндоо аюулын харанга дэлдэж байна.

Холбоо мэдээллийн сүлжээний үсрэнгүй хөгжлөөс үүдэн хяналт зохицуулалт алдагдаж оршин суугчдын толгой дээр төрөл бүрийн цахилгаан соронзон долгионы үүсгэгчүүд цаг минут тутамд янз бүрийн давтамжаар хүний эрүүл мэндэд агаарын бохирдлоос илүүтэйгээр онц хортой нөхцөлийг үүсгэж байна. Энэ бүх сөрөг үр дагавруудыг орон нутаг эрх мэдлийнхээ хүрээнд барагдуулж зохицуулах боломжгүй нь тодорхой байгаа.

IX БҮЛЭГ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

9.1 Улаанбаатар хотын хөгжлийн өнөөгийн байдалд хийсэн дүгнэлт, шийдвэрлэх асуудлууд

Нийслэл Улаанбаатар хот түүхэн хөгжлийнхөө явцад 5 удаагийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжиж, өнөөгийн дүр төрхөө олж ирсэн. Нийслэл хотын хөгжлийн хэтийн төлөвлөлтөнд хотжилтын эрчимтэй үйл явц хэр удаан үргэлжлэх нь гол үндсэн асуудал болж байна. Улсын эдийн засгийн чадавх, хүн амын шилжилт хөдөлгөөн нь Улаанбаатар хотын хүн амын механик өсөлт, өөрчлөлтөд шууд нөлөөлдөг.

2012 оны байдлаар нийслэлийн хүн ам 1 сая 227 мянга, үүнээс Улаанбаатар хотын хүн ам 1 сая 163 мянгад хүрч саятан хот боллоо. Сүүлийн 12 жилийн хугацаанд нийслэлийн хүн ам 558.2 мянгаар /56 хувь механик өсөлтөөр, 44 хувь нь ердийн өсөлтөөр/, үүнээс Улаанбаатар хотын хүн ам 437 мянган хүнээр тус тус нэмэгджээ. Энэ нь Дархан хотын хүн амаас 5.7 дахин их, Эрдэнэт хотын хүн амаас 5.1 дахин их буюу Өвөрхангай, Булган, Говьсүмбэр, Сүхбаатар, Говь-Алтай, Дундговь, Архангай гэсэн 7 аймгийн хүн амыг нийлүүлсэнтэй тэнцэх хүн хөдөө, орон нутгаас шилжин ирсэн гэсэн үг. Ийнхүү өнгөрсөн арван гаруй жилд Улаанбаатар хот асар хурдацтай өргөжин тэлж, тус хотын хүн ам 70 шахам хувиар өсч, улсын нийт хүн амын 40 гаруй хувийг эзлэх болсон нь Улаанбаатар хотын төдийгүй улс орны тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудал болоод байна. Улаанбаатар хотын хүн амын механик, огцом өсөлт нь хотын иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдрах баталгааг алдагдуулж, хотын амьдрал, хэвийн үйл ажиллагаанд бүх талын сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа үндсэн шалтгаан болж байна. Манай улсын хүн ам, зөвхөн нийслэл Улаанбаатар хотдоо зохисгүй, хэт бөөгнөрсөн байдлыг улс орны бүсчилсэн хөгжлийн алсын хараатай оновчтой бодлогын хүрээнд засаж залруулах шаардлагатай байна. Хүн амын нийт өсөлтийн гуравны хоёроос илүү хувийг механик өсөлт эзэлж байгаа нь нийслэл хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй шууд холбоотой бөгөөд улсын хэмжээнд авч үзэж шийдвэрлэх шаардлагатай бас нэг томоохон асуудал мөн.

Хотод шинээр шилжин нүүж ирсэн хүмүүсийн ихэнх нь гэр хороололд суурьшсан нь гэр хорооллыг ямар ч төлөвлөлтгүйгээр, хамгийн эрчимтэйгээр өргөжин тэлэхэд хүргэж, эзлэх талбай нь 2 дахин нэмэгдэн, 9752.0 га болж хотын суурьшлын нутаг дэвсгэрийн 59.2 хувийг эзэлж, хотын нийт хүн амын 60 гаруй хувь нь гэр хороололд амьдарч байна. Гэр хорооллын хүн ам өсч, нутаг дэвсгэр тэлэхийн хирээр хүрээлэн буй орчныг доройтуулж, сөрөг нөлөөллүүд нь зөвхөн гэр хорооллыг бус Улаанбаатар хотыг бүхэлд нь хамарч байгаа ба өвчлөл, бохирдлын үндсэн шалтгаан болсоор хүн амын амьдрах орчин эрсдэлийн түвшинд хүрч, цаашид яаралтай арга хэмжээ авахгүй бол хүрээлэн буй байгаль орчин гамшгийн түвшинд хүрэх магадлал өндөр байна.

Манай улсын ДНБ-ний 64.6 хувийг Улаанбаатарын бүст харьяалагддаг ААНБ-ууд үйлдвэрлэсэн байна. Энэ үзүүлэлт нь сүүлийн 5 жил 12 фунтээр өссөн нь Монгол улсын эдийн засаг нэг хотоос шууд хамааралтай болж байгааг харуулж байна. Гэвч аж үйлдвэрт орчин үеийн өндөр технологитой боловсруулах үйлдвэрлэлийн хувийн жин бага, байгальд халтай үйлдвэрлэл зонхилсон, үйлчилгээний салбарын технологийн түвшин хэт доогуур, ХАА-д фермерийн аж ахуй сул хөгжсөн, үүнтэй холбоотойгоор зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүн, тухайлбал сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны хангамж импортоос хараат байдалтай байна. Улаанбаатар хотод 1992-2010 онуудад хүн ам 2 дахин, хөдөлмөрийн насны хүн ам 2.5 дахин, эдийн засгийн идэвхтэй хүн ам 1.8 дахин, ажиллагсад 1.7 дахин өссөн байна. 2010 оны байдлаар 430 мянган хүн ямар нэгэн хөдөлмөр эрхэлж байна. Цаашид албан бус секторт ажиллагсдыг бүртгэлжүүлэх шаардлагатай байна. Нийт бүртгэлтэй ажиллагсдын 94 хувь Улаанбаатар хотод, 6 хувь нь дагуул хот, тосгодод ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургууль төслийн хүчин чадлаасаа 1,66 дахин хэтэрсэн ачаалалтай ажиллаж байна. Захын хороод болон төвийн хороодын хангамжийн үзүүлэлт эрс ялгаатай байгаа бөгөөд захын зарим сургуулиуд 3 ээлжээр хичээллэж байна. Улаанбаатар хотод цэцэрлэгт хамрагдалт 44 хувь байна. Үүний гол шалтгаан нь цэцэрлэгийн хангамж муу байгаагаас шууд хамаарч байна. Төрийн өмчийн цэцэрлэгүүд төслийн хүчин чадлаасаа 28.4 хувиар илүү хүүхэд хүмүүжүүлж байна. Манай улсын ихэнх их дээд сургуулиуд Улаанбаатар хотод төвлөрчээ. Улсын нийт оюутны 87.4 хувь, их, дээд сургуулиудын 79.2 хувь нийслэл Улаанбаатар хотод ноогдож байна. Гэвч сургалтын чанар зарим улс орнуудын нийслэл

хотуудын их, дээд сургуулиудын сургалтын чанартай харьцуулбал ихээхэн доогуур түвшинд байна.

Мэргэжлээрээ ажиллаж байгаа их эмч нарын 60 орчим хувь нь ажиллаж, 1 их эмчид ойролцоогоор 255 хүн ноогдож байгаа нь манай орны хувьд хамгийн өндөр үзүүлэлт байх боловч эрүүл мэндийн бусад үзүүлэлтийн хувьд тэр хэмжээгээрээ илүү байж чадахгүй байна. Жишээлбэл, 2009 оны байдлаар нийт төрөлтийн 32 гаруй хувь нь Улаанбаатар хотод ноогдож байгаа бөгөөд 1000 амьд төрөлт бүрт нялхсын эндэгдэл 19,6 байгаа нь улсын дундаж буюу 20-иос ялимгүй доогуур, төрөхийн улмаас эндсэн эхийн 43 хувь нь Улаанбаатар хотод ноогдож байна. 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсөд, нас баралтын хувьд улсын дунджаас 0.2 ба 0.9 пунктээр доогуур байна. Мөн их эмч нарын 60.6 хувь, эм зүйч нарын 81.7 хувь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны 43.1 хувь нь тус тус нийслэл хотод ажиллаж байна. Гэвч эрүүл мэндийн үйлчилгээний чанар бусад улс орны нийслэл хотуудын эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээний чанартай харьцуулбал ихээхэн доогуур түвшинд байна. Нарийн мэргэшлийн оношилгоо, эмчилгээг өндөр болон дундаж хөгжилтэй орнуудын түвшинд хийж чадахгүй байгаагаас үүдэн олон өвчтөн гадаад орнуудад оношилгоо, эмчилгээ хийлгэж их хэмжээний валют гадагш урссаар байна.

Хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх “дэд бүтцийг эхлэн барьж байгуулах” хуулиар тогтоосон дараалал алдагдан, хөгжлийн бодлого-төлөвлөлт-хэрэгжилтийн тогтолцоо, хөрөнгө оруулалтын бодлогын уялдаа орхигдсоноос үүдэн Улаанбаатар хотын дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ хангалттай бүрдээгүй байна.

Усан хангамжийн одоогийн тогдоогдсон хүчин чадал нь цаашдын эрэлтийг хангаж чадахгүй байна. Иймд цэвэр усны шинэ эх үүсвэр шаардлагатай байгаа бөгөөд үр ашигтай хувилбарыг сонгох шаардлага тулгараад байна. Усны нэгдсэн менежментийг боловсруулан шийдвэрлэх шаардлагатай.

Эрчим хүчний хангамжийн өнөөгийн хүчин чадал нь ирээдүйн эрэлтийг хангахад хүрэхгүй, хотын зарим хэсгийн дэд станцууд ачааллаа даахгүй байдалд хүрээд байгаа тул шинэ эх үүсвэрийг яаралтай барих шаардлагатай байна. Нүүрсээр ажилладаг ДЦС-ууд харьцангуй үр ашиг муутай тул технологийн шинэчлэл хийх шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүч, нар, салхины энергийг өргөнөөр ашиглах, хийн хангамжийн системийг нэвтрүүлэх, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын бүтцийг судлан эрчим хүч үйлдвэрлэх технологи нутагшуулахыг амьдрал шаардаж байна.


Хотын нийтийн ахуйн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, төвлөрсөн хангамжийн системээс хэсэгчилсэн хангамжийн системийг чухалчлах, гэр хорооллын онцлогт нийцүүлэн дэд бүтцийн хангамжийн техник, технологийн шийдлийг оновчтой тодорхойлох, өндөр технологийг нэвтрүүлэх асуудлыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай.

Төв цэвэрлэх байгууламж нь төслийн хүчин чадлаараа ажиллаж цаашдын эрэлтийг хангаж чадахгүй тул орчин үеийн өндөр (био, нано) технологээр шинэчлэн, өргөтгөх шаардлагатай. Гэр хорооллын болон алслагдсан суурингуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн техник технологийн шийдлийг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай.

Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын амьдрах орчин, орон сууцны нөхцөл байдлыг дээшлүүлэх хот байгуулалтыг дэмжсэн газрын менежментийн бодлого шийдлээ хүлээсээр байна. Мөн гэр хорооллыг хот байгуулалтын бүтцэд багтаан онцлог, нөхцөлд нь нийцсэн дэд бүтцийг бий болгох, хог, хаягдал болон бохир усыг дахин боловсруулах техник технологийн цогц шийдэл боловсруулах асуудал нэн тэргүүнд шаардлагатай. Амьдрах орчноо сайжруулахад оршин суугчдын оролцоог нэмэгдүүлж, өрхийн ариун цэврийн байгууламжийн уламжлалт хэв маяг, дадал зуршлыг өөрчлөхийн ач холбогдлыг ойлгуулж, олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх нь чухал.

Зах зээл дээр инженерийн бүрэн хангамжтай орон сууцыг гол төлөв хувийн хэвшлийнхэн иргэдэд шууд нийлүүлж байна. Эдгээр орон сууц нь зах зээлийн үнээс хэт өндөр байдгаас бага дунд орлоготой иргэдэд хүрч чадахгүй байна. Тиймээс цаашид бага дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны бодлого, мөн иргэд өөрсдийн өмчилсөн газар дээрээ инженерийн бүрэн хангамжтай орон сууцаа барих нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

Улаанбаатар хотын олон нийт үйлчилгээний төвүүдийн байршлыг оновчтой тодорхойлон хөгжүүлж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах асуудлыг төлөвлөлтөнд тусган шийдвэрлэх нь чухал.



СУДАЛГААНЫ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Улаанбаатар хотын 2020 оны ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн хөгжлийн одоогийн байдлын дагалдах судалгаанууд:

Он	Судалгааны ажлын нэр	Хуудасны тоо
2010	Нийслэлийн бүсийн одоогийн байдлын судалгаа	134
2010	Нийслэлийн болон дагуул хот тосгодын одоогийн байдлын судалгаа	169
2010	Улаанбаатар хотын одоогийн байдлын судалгаа	426
2010	Төр захиргааны анхан шатны байгууллага хороодоос авсан судалгаа	1350
2010	Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн одоогийн байдлын судалгаа	139
2010	Газар ашиглалтын судалгаа	55
2010	Суурьшлын тогтолцооны одоогийн байдлын судалгаа	56
2010	Ерөнхий төлөвлөгөөний тодотголын байгаль орчны одоогийн байдлын судалгаа	134
2010	Нийгэм эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдлын судалгаа	207
2010	Цахилгаан хангамжийн одоогийн байдлын судалгаа	74
2010	Дулаан хангамжийн одоогийн байдлын тодотгол судалгаа	48/89
2010	Усан хангамжийн шугам сүлжээний одоогийн байдлын судалгаа	29
2010	Улаанбаатар хотын барилгажсан талбайн ногоон байгууламжийн судалгаа	33
2010	Мэдээлэл холбооны сүлжээний одоогийн байдлын судалгаа	77
2010	Байгаль орчны одоогийн байдлын судалгаа	132
2010	Зам тээврийн одоогийн байдлын судалгаа	147
2010	Гудамж замын сүлжээний одоогийн байдлын судалгаа	36

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын явцад хийгдсэн нэмэлт судалгааны ажлууд		
2011	Гэр хорооллын дэд төвүүдийн судалгаа	90
2011	Үйлдвэрийн бүсийн судалгаа	181
2011	Зуслангийн бүсийн судалгаа	268
2011	Эрчимтэй таталцал нөлөөллийн бүс	73
2011	Ногоон байгууламжийн төлөвлөлт	47
2011	Нийслэлийн ногоон бүсийн төлөвлөлт	26
2011	Ерөнхий төлөвлөгөөний хог хаягдал, ариун цэврийн байгууламжийн болон гэр хорооллын дэд бүтцийн хэсэгчилсэн төлөвлөлтийн талаарх судалгаа	68
2011	Гэр хорооллыг дахин төлөвлөх зөвлөмжүүдийг харьцуулсан судалгаа	243
2011	Хот байгуулалтын хууль эрхзүйн орчны судалгаа	120
2011	Барилгын материалын үйлдвэрүүдийг хотод байршуулах, дотоодын үйлдвэрийг дэмжих хувилбарыг судалж байршлыг санал болгох талаар судалгаа	105
2011	Аялал жуулчлалын одоогийн байдлын судалгаа	28

2012 онд хийгдсэн шаардлагатай нэмэлт судалгааны ажлууд		
Он	Тайлангийн нэр	Хуудасны тоо
2012	Улаанбаатар хотын Инженер-геологийн тойм судалгаа	30
	Налайх дүүргийн Инженер-геологийн тойм судалгаа	20 хуудас, 1:5000 зураг-2 ш
	Багануур дүүргийн Инженер-геологийн тойм судалгаа	13 хуудас, 1:5000 зураг - ш
	Багахангай дүүргийн Инженер-геологийн тойм судалгаа	13 хуудас, 1:2500 зураг-1 ш
	УБ хотын зуслангийн бүсийн Инженер-геологийн тойм судалгаа	15 хуудас А2 -ш зураг
2012	Улаанбаатар хотын 2020 он хүртэлх дулаан хангамж, газрын гүний дулаан, нарны эрчим хүч, энергийг ашиглах тооцоо судалгаа	38
2012	Хот байгуулалтын хууль эрхзүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын судалгаа	40
2012	Нийслэл Улаанбаатар хотын гадаргын ба газар доорх усны нөөц, хөгжлийн ирээдүйн чиг хандлагын судалгаа	46
2012	Хөдөө аж ахуйн хөгжлийн судалгаа, төлөвлөлт	193
2012	Улаанбаатар хотын авто машины зогсоолын нягтралын судалгаа /Их тойруу хэсэг/	221
2012	Улаанбаатар хотын ложистик судалгаа /Хүнсний бус ачаа тээш/	140
2012	Улаанбаатар хотын ложистик судалгаа /Хүнсний чиглэлийн ачаа тээш/	170
2012	Улаанбаатар хотын Их тойруугаас бусад хэсгийн авто машины зогсоолын нягтралын судалгаа	191
2012	Нийслэлийн бүтээн байгуулалтын барилга угсралтын ажилд шаардагдах барилгын материалын эрэлт нийлүүлэлтийн тойм судалгаа ба Нийслэлийн бүтээн байгуулалтын барилга угсралтын ажилд бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа барилгын материалын үйлдвэрийн байршлын судалгаа	63
2012	Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалууд	37
2012	Улаанбаатар хотын агаарын болон тоосны бохирдлын тулгамдсан асуудалд	44
2012	Нийслэлийн нутаг дэвсгэрийн ул хөрсний улирлын хөлдөлт гэсэлт	28
2012	Гэр сууцны хорооллын хөгжил, төлөвлөлт	158
2012	Орон сууцны хорооллын хөгжил, төлөвлөлт	197
2012	Улаанбаатар хотын эрүүл ахуйн тулгамдаж байгаа үндсэн асуудлууд	23